

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН 2026 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар оруулах/
1	2	3	4	5	6	7
Стратегийн төлөвлөгөөний зорилго 1: Нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах, гадаад, дотоод харилцааг өргөжүүлж, ажил олгогч, даатгуулагчтай хамтран ажиллах;						
Зорилт 1: Нийгмийн даатгалын хууль тогтоомж, нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудлаар судалгаа хийж, санал боловсруулах,						
1.1.	“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичигт тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг хангуулах;	-	Бодлогын баримт бичгийн биелэлтийн тоо	6	6	Засгийн газрын 2025 оны “Журам батлах тухай” 43 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-д Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн гүйцэтгэлийн болон хяналт-шинжилгээ дүнг тайлагнах цаглабрыг баталсан. Засгийн газрын 2026 оны 144 дүгээр тогтоолоор уг цаглаварт өөрчлөлт орсонтой холбогдуулан тайлант оны эхний хагас жилд гүйцэтгэлийг тайлагнах бодлогын баримт бичиг байхгүй байна. Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний эхний хагас биелэлтийг 07 дугаар сарын 01-ний дотор ГБХНХЯ-нд хүргүүлэхээр ажиллаж байна.
1.2.	Нийгмийн даатгалын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах, холбогдох тооцоо,		Боловсруулсан хуулийн төслийн тоо	7	2	Нийгмийн даатгалын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэв. Үүнд: 1.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд нэмэлт оруулах саналыг

	судалгааг ГБХНХЯ-нд хүргүүлэх; хийж					танилцуулгын хамт Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны “Санал хүргүүлэх тухай” 01/301 дугаар албан бичгээр ГБХНХЯ-нд хүргүүлэв. 2.Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг ажлын өдрөөр олгох нэмэлт оруулах саналыг танилцуулгын хамт Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны “Санал хүргүүлэх тухай” 01/610 дугаар албан бичгээр ГБХНХЯ-нд хүргүүлэв. 3.Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны “Санал хүргүүлэх тухай” 01/788 дугаар албан бичгээр ГБХНХЯ-нд хүргүүлэв. 4.Ажилгүйдлийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн санхүүгийн эх үүсвэрийг шийдвэрлэх зорилгоор Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсөвт өөрчлөлт оруулах, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын шимтгэлийн хувь хэмжээнд өөрчлөлт оруулах, Нийгмийн даатгалын ерөнхий хуульд өөрчлөлт оруулах саналыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны “Санал хүргүүлэх тухай” 01/904 дугаар албан бичгээр ГБХНХЯ-нд хүргүүлэв. 5.Батлан хамгаалах яамнаас Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан өндөр насны тэтгэврийн тусгай зохицуулалттай ижил агуулга бүхий нэмэлт, өөрчлөлтийг оруулахаар боловсруулж байгаатай холбогдуулан Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт оруулах дагалдах хуулийн төслийн саналыг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны “Санал хүргүүлэх тухай” 01/1229 дугаар албан бичгээр ГБХНХЯ-нд хүргүүлэв. 6. Нийгмийн даатгалын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах ажлын хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны
--	---	--	--	--	--	---

						Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газартай хамтарсан ажлын хэсэгт 2026.05.26-06.11-ний хугацаанд ажиллаж, хуулийн төслийг Засгийн газрын 2026 оны 06 дугаар 10-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн УИХ-д өргөн барихаар шийдвэрлэв..
			Тооцоо, судалгааны тоо	4	2	1.Нийгмийн даатгалын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах ажлын хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбоотой 9 төрлийн, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбоотой 9 төрлийн, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахтай холбоотой 2 төрлийн, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт холбоотой 2 төрлийн, нийт 22 төрлийн тооцоо, судалгаагаар нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагад нөлөөлөх нөлөөллийг тооцож, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны 01/1174 дугаар албан бичгээр ГБХНХЯ-нд хүргүүлэв. 2.УИХ-ын гишүүн Б.Түвшин нарын боловсруулсан Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн нөлөөллийн 5 төрлийн тооцоог боловсруулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны 01/1192 дугаар албан бичгээр ГБХНХЯ-нд хүргүүлэв. 3. Нийгмийн даатгалын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах ажлын хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газартай хамтарсан ажлын хэсэгт 2026.05.26-06.11-ний өдрүүдэд ажиллаж, хуулийн төслийн дагалдах 29 тооцооллыг хийж нягтлан нэгтгэв.
1.3	Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/, Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль болон		НДГ-т хүргүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн тоо	9	2	Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой 2026 оны эхний хагас жилд дараах 9 зөвлөмж, чиглэлийг аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудад хүргүүлэн, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав. Үүнд: 1.Засгийн газрын 2025 оны “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх, тэтгэврийн доод хэмжээг шинэчлэн

	тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой батлагдсан дүрэм, журмын хэрэгжилтийг зохион байгуулах;					тогтоох тухай” 242 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зөвлөмжийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны 04/13 дугаар албан бичгээр; 2.Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг 2026.01.01-ний өдрөөс дагаж мөрдөхтэй холбоотой анхаарах асуудлуудын талаарх зөвлөмжийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны 01/17 дугаар албан бичгээр; 3.БНСУ-ын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвд Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хууль болон Нийгмийн даатгалын багц хуулийг 2026.01.01-ний өрдөөс дагаж мөрдөх зөвлөмжийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны 01/45 дугаар албан бичгээр; 4.Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсэгт заасан үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын улмаас ажил олгогчид учирсан хохирлыг арилгах, хэвийн үйл ажиллагааг сэргээх зорилгоор сул зогссон хугацааг тогтооход баримтлах зөвлөмжийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны 01/412 дугаар албан бичгээр; 5.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны “Сэргээн засах болон сувиллын тусламж, үйлчилгээний төлбөрийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох хэмжээг тогтоох тухай” 12 дугаар тогтоолоор баталсан (нэг хоногт 110,000 төгрөг) хэмжээгээр тооцон, сувиллын тусламж, үйлчилгээний төлбөрийг батлагдсан төсвийн хүрээнд тухайн тусламж, үйлчилгээ үзүүлсэн сувиллын байгууллагад олгож, хяналт тавьж ажиллах чиглэлийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны 04/855 дугаар албан бичгээр; 6.Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын Тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийн
--	--	--	--	--	--	--

						хэрэгжилтийг зохион байгуулах зөвлөмжийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны 04/928 дугаар албан бичгээр; 7.Монгол Улсын Ерөнхий сайдын 2026 оны “Макро эдийн засгийн өсөлтийг хадгалж, өрхийн бодит орлогыг нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” 04 дүгээр албан даалгаврыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлийн 2026 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Зорилтот өрхийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, амьжиргаа дээшлүүлэх хөтөлбөр”-ийн 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлуудыг хэрэгжүүлэх чиглэлийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны 01/998 дугаар албан бичгээр; 8.Төрийн албаны тухай хуулийн 46.1.1, 46.1.2 дахь заалтад заасан үндэслэлээр төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, төрийн албаны нөөцөд бүртгэлтэй даатгуулагчид ажилгүйдлийн тэтгэмж олгохтой холбоотой зөвлөмжийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны 01/1252 дугаар албан бичгээр; 9.Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны “Заавар батлах тухай” А/153 дугаар тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын газрын архиваас нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагаа олгоход баримтлах заавар”-ыг хэрэгжүүлэх чиглэлийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны 04/1652 дугаар албан бичгээр тус тус хүргүүлсэн болно.
			Батлуулсан төлөвлөгөө	1	1	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны “Төлөвлөгөө батлах тухай” А/19 дүгээр тушаалаар “Нийгмийн даатгалд 2026 онд хамруулах ажил олгогч, албан журам, сайн дураар даатгуулагчийн тооны төлөвлөгөө”-г баталж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав.
			Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	Албан журам- 4.5% Сайн дурын даатгал 5.7%	100%	Нийгмийн даатгалд 2026 онд хамруулах ажил олгогч, албан журмын болон сайн дурын даатгуулагчийн тооны төлөвлөгөөг аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газруудад хүргүүлж, хэрэгжилтэд сар бүр хяналт тавин ажиллаж байна. Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч аж ажил олгогчийн тоо 2026 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн байдлаар 60,257 болж, өмнөх оны мөн үеэс 845 хүнээр,

						албан журмын даатгуулагчийн тоо 971,685 болж, 10,982-оор, сайн дурын даатгуулагчийн тоо 140,983 болж, 20,330 хүнээр, үүнээс малчин, туслах малчин даатгуулагчийн тоо 53,994 болж, өмнөх оны мөн үеэс 16,224 хүнээр тус тус өссөн дүнтэй байна.
1.4	Тэтгэврийн даатгалын нэрийн дансны 2025 оны орлогод хүү тооцон эцсийн үлдэгдлийн талаарх мэдээллийг даатгуулагчдад хүргэх;	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	2	3	1.Даатгуулагчийн тэтгэврийн даатгалын нэрийн дансны орлогод хүү тооцох, тухайн онд бүртгэсэн шимтгэлийн орлогыг тодорхойлох, жилийн эцсийн үлдэгдлийг тооцох, үлдэгдлийн талаарх мэдээллийг даатгуулагчдад хүргэхтэй холбоотой системийн шинэчлэлт хөгжүүлэлтийг хийж, даатгуулагч төрийн үйлчилгээний e-mongolia.mn нэдсэн порталаас тэтгэврийн даатгалын нэрийн дансны лавлагааг авах боломжийг бүрдүүлэв. 2.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны “Журам батлах тухай” 01 дүгээр тогтоолоор баталсан “Нэрийн дансыг нээх, бүртгэх, хөтлөх, даатгуулагчийн гарааны үлдэгдлийг тооцохтой холбогдсон харилцааг зохицуулах журам”-д заасны дагуу тэтгэврийн даатгалын нэрийн дансны 2024 оны эцсийн үлдэгдэл, 2025 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг 11.28 хувь байхаар тооцож, ҮСХ, ГБХНХЯ-ны саналыг тус тус авсны дагуу Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын “Санал хүргүүлэх тухай” 01/1370 дугаар албан бичгээр Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн ажлын албанд хүргүүлэв.
1.5	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2026 оны төлөвлөгөөг боловсруулж, НДҮЗ-өөр батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;		Батлуулсан төлөвлөгөө,	1	1	1.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 07 дугаар тогтоолоор баталсан “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах байгууллагыг сонгох, арга хэмжээний зардлын төлбөрийг санхүүжүүлэх, хяналт тавих журам”-ын 1.4-т заасны дагуу “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжих урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2026 оны төлөвлөгөө”-ний төслийг боловсруулж, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны “Төлөвлөгөөний төсөл хүргүүлэх тухай” 01/599 дугаар албан бичгээр Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын албанд хүргүүлэв.

						2.Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн хуралдаанаар төлөвлөгөөний төслийг хэлэлцүүлж, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2026 оны “Төлөвлөгөө батлах тухай” 04 дүгээр тогтоолоор “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын санхүүжүүлэх урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2026 оны төлөвлөгөө”-г батлуулав.
			Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	43.9%	100%	Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2026 оны “Төлөвлөгөө батлах тухай” 04 дүгээр тогтоолоор баталсан “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас санхүүжүүлэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний 2026 оны төлөвлөгөө”-нд тусгагдсан 41 арга хэмжээнээс 9 арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 139.6 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон бөгөөд 9 арга хэмжээг хэрэгжүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах ажил явагдаж байна.
1.6	Нийгмийн даатгалын салбарын статистик, сангийн үндсэн үзүүлэлтүүдийн мэдээ, судалгааг хугацаанд нь гаргах;		Статистик үзүүлэлтийн нэгтгэл	1	1	Нийгмийн даатгалын салбарын 2025 оны албан ёсны статистик үзүүлэлтийг хугацаанд нь гаргаж, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны 01/1187 дугаар албан бичгээр ГБХНХЯ, ҮСХ-нд тус тус хүргүүлэв.
			Боловсруулсан мэдээ, судалгааны тоо	12	12	Нийгмийн даатгалын хамрагдалт, тэтгэвэр, тэтгэмж авагчдын 2025 оны 12 сар, 2026 оны 01-05 сарын мэдээг хугацаанд нь гаргаж, албан бичгээр ГБХНХЯ, ҮСХ-нд тус тус хүргүүлэв.
1.7	Монгол Улсын 2026 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулах;		Батлуулсан төлөвлөгөө	4	2	1.Нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны урсгал зардлын 2026 оны төсвийн аймаг, дүүргийн болон аймаг, дүүргийн сар, улирлын нарийвчилсан хуваарийг боловсруулж, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны “Үйл ажиллагааны урсгал зардлын 2026 оны төсвийн хуваарь батлах тухай” А/03 дугаар тушаалаар батлав. Уг тушаалд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны А/31, А/57, А/136 дугаар тушаалаар тус тус өөрчлөлт оруулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав. 2.Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн аймаг, дүүргийн болон аймаг, дүүргийн сар, улирлын нарийвчилсан хуваарийг тус тус боловсруулж,

						Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны “Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн хуваарь батлах тухай” А/02 дугаар тушаалаар батлав. Уг тушаалд Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны А/51, А/59, А/93, А/138, А/149 дүгээр тушаалуудаар тус тус өөрчлөлт оруулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав. 3.Нийгмийн даатгалын сангийн болон нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны урсгал зардлын 2026 оны төсөвт тодотгол хийх саналыг боловсруулж, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны "Санал хүргүүлэх тухай" 01/1281 дугаар албан бичгээр ГБХНХЯ-нд хүргүүлэв.
1.8	Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын 2027-2029 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2027 оны жилийн хязгаарын саналыг боловсруулж, ГБХНХЯ-нд хуулиар тогтоосон хугацаанд хүргүүлэх;		Зохион байгуулсан арга хэмжээний тоо	3	3	1.Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын, нийгмийн даатгалын байгууллагуудын үйл ажиллагааны урсгал зардлын болон хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зардлын 2027-2029 оны төсвийн төсвийн төсөл, төсөөлийн саналыг боловсруулж, ирүүлэх чиглэлийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны “Төсвийн төсөл, төсөөллийн санал ирүүлэх тухай” 01/1623 дугаар албан бичгээр аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газруудад хүргүүлэв.
			Боловсруулсан саналын тоо	3	3	1.Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын 2027-2029 оны төсвийн хүрээний мэдэгдлийн саналыг боловсруулж, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны “Санал хүргүүлэх тухай” 01/615 дугаар албан бичгээр ГБХНХЯ-нд хуулийн хугацаанд хүргүүлэв. 2.Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын 2027 оны төсвийн жилийн хязгаарын саналыг боловсруулан Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны “Санал хүргүүлэх тухай” 02/1669 дугаар албан бичгээр ГБХНХЯ-нд хуулийн хугацаанд хүргүүлэв.
Зорилт 2. Нийгмийн хамгааллын чиглэлээр байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг зохион байгуулах, төр хувийн хэвшлийн түншлэлийн харилцааг хөгжүүлэх,						
2.1	Нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах олон улсын хэлэлцээрийн		Хэрэгжилтийг хангуулсан хэлэлцээрийн тоо	6	6	1.БНМАУ, ЗСБНХУ-ын хооронд нийгэм хангамжийн салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээрийн хүрээнд ОХУ-д ажилласан хугацаагаа баталгаажуулах хүсэлт гаргасан 38 хүний хүсэлтийг ОХУ-ын тэтгэврийн санд албан бичгээр хүргүүлж, хоёр улсад ажилласан

	хэрэгжилтийг зохион байгуулах, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх;					хугацаагаа баталгаажуулахаар хүсэлт гаргасан 25 хүний ажилласан жилийн тодорхойлолтыг баталгаажуулан холбогдох байгууллагад хүргүүлж, 8 хүнд хэлэлцээртэй холбоотой мэдээлэл, зөвлөгөө өгөв. 2.БНСУ, Монгол Улсын Засгийн газар хооронд байгуулсан нийгмийн хамгааллын тухай хэлэлцээрийн хүрээнд БНСУ-ын Үндэсний тэтгэврийн албанд шимтгэл төлсөн 20 хүний 69.8 сая вонны шимтгэлийн буцаан олголтын нэхэмжлэх, баримт бичгийг хүлээн авч Үндэсний тэтгэврийн албанд хүргүүлэв. Мөн хөдөлмөрийн гэрээгээр БНСУ-д ажилласан иргэдийн тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн төлүүлэх чиглэлийг БНСУ дахь Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний төвийн Нийгмийн даатгалын тасагт хүргүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллав. 3.Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Чех Улс хоорондын хэлэлцээрийн хүрээнд Бүгд Найрамдах Чех Улсад тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан 52 хүний Монгол Улсад нийгмийн даатгалын шимтгэл төлж ажилласан тухай лавлагаа, 21 хүний Бүгд Найрамдах Чех Улсад даатгалд хамрагдсан хугацааны гэрчилгээний хүсэлтийг БНЧУ-ын талд хүргүүлэв. 4.Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс, Унгар Улс хоорондын хэлэлцээрийн хүрээнд тус улсаас тэтгэвэр тогтоолгохоор хүсэлт гаргасан болон мэдээлэл солилцох 19 хүний, Монгол Улсад шимтгэл төлж ажилласан жилийг баталгаажуулах 13 хүний маягтын дагуу, Унгар улсаас өндөр насны тэтгэвэр авагч 30 хүний оршин суугаа газрын хаягийн баталгаажуулалтыг Унгар Улсын талд хүргүүлэв. 5.Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс болон Бүгд Найрамдах Польш Улс хоорондын хэлэлцээрийн хүрээнд Бүгд Найрамдах Польш Улсад өндөр насны тэтгэвэр тогтоолгох хүсэлт гаргасан 7 хүний мэдээллийг Польш Улсын талд хүргүүлэв. 6.Нийгмийн хамгааллын тухай Монгол Улс, Бүгд Найрамдах Турк Улс хоорондын хэлэлцээрийн хүрээнд 1 хүний мэдээллийг Бүгд Найрамдах Турк Улсын Нийгмийн даатгалын байгууллагад хүргүүлэв. 7.Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын тэтгэврийн
--	--	--	--	--	--	---

						асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийн хүрээнд Монгол Улс болон Бүгд Найрамдах Казахстан Улсад 1998 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө шимтгэл төлж, ажилласан 97 хүний мэдээллийг маягтын дагуу Бүгд Найрамдах Казахстан Улсын холбогдох мужуудын тэтгэврийн асуудал хариуцсан байгууллагуудад хүргүүлэв.
			Хэлэлцээр шинээр байгуулахтай холбоотой ажилласан ажлын хэсгийн тоо	5	1	Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээрийг 2026.04.01-нээс эхлэн хэрэгжүүлэхтэй холбоотой тус улсын Хөдөлмөр, хүн амын нийгмийн хамгааллын яамны Нийгмийн хангамж, нийгмийн даатгалын газрын Орлогч дарга Хасенова Баян Зарлыковнатай 2026 оны 03 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулсан цахим уулзалтад оролцов. Уулзалтаар талууд Хэлэлцээрийг хэрэгжүүлэхтэй холбоотой бэлтгэл ажлын явцын талаар харилцан мэдээлэл солилцов.
			Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо	10	5	1.“Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Казахстан Улсын Засгийн газар хоорондын тэтгэврийн асуудлаар хамтран ажиллах тухай хэлэлцээр”-ийг 2026 оны 04 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжүүлж эхлэхтэй холбогдуулан 2026 оны 03 дугаар сарын 31-ний өдөр аймаг, дүүргийн НДГ-ын дарга, байцаагч, ажилтнуудад цахим сургалт зохион байгуулж, холбогдох зөвлөмж, чиглэлийг өгөв. 2.Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газартай хамтран Монгол Улсаас БНСУ-д хөдөлмөрийн гэрээгээр ажиллахаар явж байгаа 50 гаруй иргэдэд Нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах хэлэлцээр болон нийгмийн даатгалын хууль тогтоомжийн талаар 2 удаа зөвлөгөө, мэдээлэл өгч ажиллав. 3.Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох, сэргээх, баталгаажуулах шалгалтад орох албан хаагчдад “Нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах талаар Олон Улсын хэлэлцээрүүд” болон “Төрөөс тэтгэврийн шинэчлэлийн талаар баримтлах бодлого 2015-2030” сэдвүүдээр цахим сургалт зохион байгуулав.

						4.Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улс (хуучин нэрээр), Бүгд Найрамдах Солонгос Улс, Унгар Улс, Бүгд Найрамдах Чех Улс, Бүгд Найрамдах Польш Улс, Бүгд Найрамдах Турк Улс, Бүгд Найрамдах Казахстан Улсуудтай Нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах хэлэлцээрийн дагуу иргэдийн нийгмийн даатгалын шимтгэл төлж, ажилласан нийт жил, сарыг тодорхойлохдоо 2 улсад нийгмийн даатгалын шимтгэл төлж, ажилласан давхцаагүй хугацааг нэгтгэн тооцохтой холбоотой системийн хөгжүүлэлтийг Нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн систем /СИКОС/-д хийж байна.
Стратегийн төлөвлөгөөний зорилго 2: Нийгмийн даатгалын хамрах хүрээг өргөжүүлэн сангийн орлогыг бүрдүүлэн нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тогтвортой, бие даасан найдвартай байдлыг хангах замаар сангийн зарлагын гүйцэтгэлийг хангах, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардал, хөнгөлөлт, чөлөөлөлтийг хуулиар тогтоосон хугацаанд олгох, хяналт шалгалт, шинжилгээ, үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах;						
Зорилт 3. Нийгмийн даатгалын сангийн орлогыг бүрдүүлэх, хамралтыг нэмэгдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлын санхүүжилт, шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлтийг хуулиар тогтоосон хугацаанд олгох, төсвийн гүйцэтгэлийг хангах, нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;						
3.1	Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хүрээнд даатгуулагчдад тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийг хуульд заасан хугацаанд олгох;	6,584,769.2 сая төгрөг	Төсвийн зардлыг хэтрүүлэхгүй байна.	5,882,758.8 сая төгрөг	6,584,769.2 сая төгрөг	Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хуулийн хүрээнд эхний хагас жилд 3,346.6 тэрбум төгрөгийн тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардал олгохоос 3,334.7 тэрбум төгрөг олгож 99.7 хувийн гүйцэтгэлтэй байна. Нийгмийн даатгалын 33 байгууллагын сангийн төсвийн гүйцэтгэлийн сар бүрийн мэдээг нэгтгэн Сангийн Яамны Төрийн сангийн газарт 6 удаа хүргүүлэв.
3.2	Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан бэлтгэх, төсвийн гүйцэтгэлийг тайлагнах ажлыг зохион байгуулах;	-	Тайлагнасан тоо	2	2	Нийгмийн даатгалын 33 байгууллагын сангийн 2025 оны санхүүгийн тайлан бэлтгэх, төсвийн гүйцэтгэлийг тайлагнах ажлыг зохион байгуулснаар Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн 2025 оны нэгтгэсэн тайланг Үндэсний аудитын газар, Сангийн яам, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн Ажлын албанд тус тус хүргүүлэв. Үндэсний аудитын газраас Нийгмийн даатгалын сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Чингис хаан банк ХХК, Капитал банкн дахь Банкны эрх хүлээн авагч, олон жилийн насжилттай өмнөх онуудын авлагын үлдэгдлийн дүнгээр хязгаарласан үр нөлөөг эс тооцвол Төсвийн тухай хууль, Нягтлан бодох

						бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан гэж дүгнэсэн. Үндэсний аудитын газар болон аймаг, Нийслэлийн төрийн аудитын байгууллагатай хамтран ажилласны үр дүнд Нийгмийн даатгалын байгууллагуудын сангийн 2025 оны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланд 100 хувь “Өөрчлөлтгүй” дүгнэлт авсан.
3.3	Нийгмийн даатгалын байгууллагын санхүүгийн тайлан бэлтгэх, төсвийн гүйцэтгэлийг тайлагнах ажлыг зохион байгуулах;	-	Тайлагнасан тоо	2	2	Нийгмийн даатгалын байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн 2025 оны нэгтгэсэн тайланг Үндэсний аудитын газар, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд тус тус хүргүүлсэн. Үндэсний аудитын газраас Нийгмийн даатгалын байгууллагын төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр нэгтгэсэн санхүү, төсвийн гүйцэтгэлд “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгч, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан гэж дүгнэсэн.
4.1	Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах ажлыг зохион байгуулах, гэрээний биелэлтийг хангах;	-	Өгөөжийн хувь	9% - 15%	9% - 15%	Нийгмийн даатгалын сангийн чөлөөт үлдэгдлийг холбогдох хууль тогтоомж, журмын хүрээнд зөвшөөрөгдсөн санхүүгийн хэрэгсэлд байршуулж, гэрээний хэрэгжилтийг ханган ажилласнаар нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг 9.0-15.11 хувийн хүүгийн өгөөжөөр тогтвортой өсгөх нөхцөлийг бүрдүүлэв. Үүнд: <u>1.Засгийн газрын үнэт цаасанд хөрөнгө оруулав.</u> Засгийн газрын дотоод үнэт цаас худалдах, худалдан авах 2024 оны гэрээ болон 2025 оны нэмэлт өөрчлөлтийн дагуу байршуулсан 300.0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаас 2026 оны 05 дугаар сарын 15-ны өдөр 13.9 тэрбум төгрөгийн хүүгийн орлогыг хүлээн авч сангийн хөрөнгийг нэмэгдүүлэв. Мөн Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 32 дугаар тогтоолын дагуу Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай 2026 оны 02 дугаар сарын 05-ны өдөр 41/НДХ-26/02 дугаартай “Засгийн газрын үнэт цаас худалдах, худалдан авах гэрээ”-г байгуулж, эхний 75.0 тэрбум

					төгрөгийг жилийн 10.0 хувийн хүүтэйгээр 3 жил, хоёр дахь 75.0 тэрбум төгрөгийг жилийн 10.5 хувийн хүүтэй 5 жилийн хугацаатайгаар нийт 150.0 тэрбум төгрөгөөр Засгийн газрын үнэт цаас худалдан авсан ба хугацааны эцэст 61.9 тэрбум төгрөгийн хүүгийн орлого олох боломжийг бүрдүүлсэн. <u>2.Хугацаатай мөнгөн хадгаламжид байршуулсан.</u> Арилжааны банкуудтай 2025 онд байгуулсан 700.0 тэрбум төгрөгийн мөнгөн хадгаламжийн гэрээний дагуу 2026 оны эхний хагас жилд 34.8 тэрбум төгрөгийн хүүгийн орлогыг хүлээн авч, сангийн хөрөнгийг нэмэгдүүллээ. Тус мөнгөн хадгаламжийн гэрээний хугацаа 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөр дуусгавар болохтой холбогдуулан Засгийн газрын 2024 оны 254 дүгээр тогтоолоор баталсан журмын дагуу арилжааны банкуудтай (Хаан банк, Худалдаа хөгжлийн банк, Голомт банк, Төрийн банк) байгуулсан “Мөнгөн хадгаламжийн гэрээ” болон Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн дэргэдэх Мэргэжлийн хорооны 2026 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн зөвлөмжийг тус тус үндэслэн гэрээний хугацааг сунгах асуудлаар банкуудтай хэлцэл хийх ажлыг зохион байгуулсан. Хэлцлийн үр дүнд хадгаламжийн жилийн хүүгийн хэмжээг Хаан банктай 15 хувиар, Худалдаа хөгжлийн банк болон Төрийн банктай 15.11 хувийн хүүгээр харилцан тохиролцож, гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулан нийт 541.6 тэрбум төгрөгийг 2027 оны 05 дугаар сарын 02-ны өдрийг хүртэл нэг жилийн хугацаатайгаар сунгав. (Голомт банк 2025 оны 05 дугаар сарын 02-ны өдөр байгуулсан мөнгөн хадгаламжийн гэрээнд заасан хүүгийн хэмжээнээс доогуур буюу 14 хувийн хүүгийн санал ирүүлсэн тул тус банктай байгуулсан хадгаламжийн гэрээг сунгаагүй болно.) Хадгаламжийн гэрээ сунгасан 3 банкнаас хугацааны эцэст нийт 81.5 тэрбум төгрөгийн хүүгийн орлого төвлөрүүлж, сангийн хөрөнгийг өсгөн арвижуулах боломжийг бүрдүүлсэн. <u>3.Мөнгөн хадгаламжийн 2026 оны хүүгийн доод хэмжээг тогтоосон.</u>
--	--	--	--	--	---

						Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 13 дугаар зүйлийн 13.8 дахь хэсэгт заасны дагуу холбогдох судалгаа, тооцооллыг хийж, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлснээр “Мөнгөн хадгаламжийн 2026 оны хүүгийн доод хэмжээг батлах тухай” 05 дугаар тогтоолоор хүүгийн доод хэмжээг 13.94 хувиар батлууллаа.
4.2	Тэтгэврийн нөөц санг бүрдүүлэх, санхүүгийн хэрэгсэлд хөрөнгө оруулах, хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэх, даатгуулагч тус бүрээр хуваарилах ажлыг зохион байгуулах;	-	Чөлөөт үлдэгдлийг хувь	292.2 тэрбум	5% нэмэгдүүлнэ .	Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нөөц сангийн хөрөнгийг даатгуулагчийн саналд үндэслэн хөрөнгө оруулж, итгэмжлэн удирдах чиг үүргийг Нийгмийн даатгалын ерөнхий газар хэрэгжүүлэхээр хуульчилсан. Энэхүү чиг үүргийн хүрээнд тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийг зөвшөөрөгдсөн санхүүгийн хэрэгсэлд үр ашигтай байршуулж, жилийн 10.0-15.11 хувийн өгөөжөөр өсгөн арвижуулах нөхцөлийг бүрдүүлэн ажиллав. <u>1.Засгийн газрын үнэт цаасанд хөрөнгө оруулав.</u> Тэтгэврийн нөөц сангийн мөнгөн хөрөнгөнөөс 2026 оны эхний хагас жилд 85.0 тэрбум төгрөгөөр Засгийн газрын дотоод үнэт цаасанд хөрөнгө оруулснаар хугацааны эцэст 35.6 тэрбум төгрөгөөр тэтгэврийн нөөц сангийн хөрөнгө өснө. <u>2.Хугацаатай мөнгөн хадгаламжид байршуулсан.</u> Тэтгэврийн нөөц сангийн хөрөнгийг 2025 онд мөнгөн хадгаламжид хөрөнгө оруулсны өгөөжийг сар бүрийн эцэст хүлээн авахаар гэрээнд тусгасан ба хугацааны эцэст 32.5 тэрбум төгрөгийн өгөөж хүртэнэ. 2026 оны эхний хагас байдлаар 16.2 тэрбум төгрөгийн хүүгийн орлогыг хүлээн авч, нөөц сангийн хөрөнгийг нэмэгдүүлнэ. <u>3.Тэтгэврийн нөөц сангийн харилцах дансанд хөрөнгө төвлөрүүлэв.</u> Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлд тэтгэврийн хуваарилалтын тогтолцооноос хуримтлалын тогтолцоонд үе шаттай шилжих зорилгоор даатгуулагчийн нэрийн дансны мөнгөжүүлсэн орлогыг байршуулах тэтгэврийн нөөц сантай байна гэж заасны дагуу 2026 оны эхний хагас жилд тус санд 100.0 тэрбум төгрөгийг нэмж төвлөрүүлснээр 2026 оны 06 дугаар сарын 05-ны

						өдрийн байдлаар нөөц сангийн харилцах дансанд 116.4 тэрбум төгрөг байна. Мөнгөжүүлсэн орлогын мэдээллийг иргэд, даатгуулагчдад гар утасны нийгмийн даатгал аппликейшн, https://portal.ndaatgal.mn/ систем, И-Монголиа системээр тогтмол ил тод мэдээлж ажиллав.
4.3	Капитал банк ХХК дахь Банкны эрх хүлээн авагч болон Чингис хаан банк ХХК-иас нэхэмжилсэн өр төлбөрийг барагдуулах ажлыг эрчимжүүлэн ажиллах;		Капитал банкны өр төлбөр, бууралт хувь	57.6 тэрбум төгрөг	5% бууруулна	Капитал банк ХХК дахь Банкны Эрх хүлээн авагчаас нэхэмжилсэн өр төлбөрийг барагдуулах ажлыг зохион байгуулан ажилласнаар 57.6 тэрбум төгрөгийн оны эхний үлдэгдлээс 2026 оны эхний хагас жилд 6.5 тэрбум төгрөгийг мөнгөн хөрөнгөөр барагдуулж, өр төлбөрийн үлдэгдлийг 11.3 хувиар бууруулж, 51.1 тэрбум төгрөгт хүрсэн үр дүнтэй ажиллав.
			Чингис хаан банкны өр төлбөр, бууралт хувь	83.6 тэрбум төгрөг		Чингис хаан банк ХХК-ийн 83.6 тэрбум төгрөгийн 2026 оны эхний үлдэгдлийг бууруулах олон арга хэмжээ авснаар эхний хагас жилд 1.9 тэрбум төгрөгийг мөнгөн хөрөнгөөр, 4.6 тэрбум төгрөгийг хөрөнгөөр нийт 6.4 тэрбум төгрөгөөр барагдуулснаар өр төлбөрийн үлдэгдэл 77.1 тэрбум төгрөг болж, 7.7 хувиар бууруулсан үр дүнтэй ажиллав.
4.4	Нийгмийн даатгалын байгууллагуудын өмчийн харилцаа, худалдан авах ажиллагаа, үндсэн хөрөнгийн эзэмшилт, ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих, удирдлагаар хангах;		Хэрэгжилтийн хувь	3,474.5 сая төгрөг	100%	Нийгмийн даатгалын ерөнхий газрын урсгал үйл ажиллагааны зардлын 2026 оны батлагдсан төсвийн хүрээнд хэрэгжүүлэх 156.3 сая төгрөгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг цахим системд оруулж батлуулсан. Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын үйл ажиллагаа, хууль тогтоомжтой холбоотой мэдээлэл, зөвлөгөө өгөх сургалт, сурталчилгааны 564.0 сая төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг худалдан авах ажиллагааны цахим системд оруулж батлуулсан. Нийт 720.3 сая төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталж, худалдан авах ажиллагааны цахим системээр хэрэгжүүлж ажилласан. Нийгмийн даатгалын байгууллагуудад шаардлагатай маягтыг хэвлүүлэхээр “Агаст вела” ХХК, “Адмон” ХХК, “Удам соёл” ХХК зэрэг хэвлэлийн үйлчилгээ эрхэлдэг компаниудаас үнийн санал авч хамгийн бага үнийн санал ирүүлсэн “Удам соёл” ХХК-тай НД-83/26 дугаартай “Ажил гүйцэтгэх гэрээ”-г байгуулан 9.4 сая төгрөгийн үнэ бүхий 10 нэр төрлийн 66,470 ширхэг

						маягтыг хэвлүүлэн, бүрэн гүйцэд хүлээн авч тооцоо нийлсэн. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2026 оны зөвшөөрлийн дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 9 нэрийн, нийт 10.5 сая төгрөгийн балансын үнэ, 1.1 сая төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хөрөнгийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны “Үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх тухай” А/117 дугаар тушаалаар Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын газарт шилжүүлсэн. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хүлээлцэж, нягтлан бодох бүртгэлд тусган биелэлтийг ТӨБЗГ-т биелэлтийг хүргүүлж ажилласан.
З о р						
5.1	Бодлогын баримт бичиг, тогтоол шийдвэрийн биелэлт, байгууллагын үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд үнэлгээ өгөх, удирдлагыг бодит, мэдээллээр хангах;		Хяналт-шинжилгээний тайлангийн тоо;	12	11	1.Засгийн газрын 2026 оны 144 дүгээр тогтоолоор Засгийн газрын 2025 оны “Журам батлах тухай” 43 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-д Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн гүйцэтгэлийн болон хяналт-шинжилгээ дүнг тайлагнах цаглабарт өөрчлөлт оруулсан тул тайлант оны эхний хагас жилд гүйцэтгэлийг тайлагнах бодлогын баримт бичиг байхгүй боловч Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн 2026 оны төлөвлөгөөний эхний хагас биелэлтэд хяналт-шинжилгээ хийж 2026 оны 07 дугаар сарын 01-ний дотор Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэхээр бэлтгэж байна. 2. Нийгмийн даатгалын ерөнхий газрын хяналтад авсан Монгол Улсын хууль, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын албан даалгавар, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын нийт 37 шийдвэрийн 68 заалт байна. Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд хяналтад авсан Монгол Улсын хууль, УИХ-ын байнгын хорооны тогтоол, Засгийн газрын тогтоол, Ерөнхий сайдын
			Хугацаанд нь хүргүүлсэн байдал;	12	11	

						захирамж, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын албан даалгавар, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол зэрэг нийт 37 хууль тогтоомж, тогтоол, шийдвэрийн 68 заалтын биелэлтийг 2025 оны жилийн эцсийн байдлаар 53 (88.3%) нь “Хэрэгжсэн”, 7(5.83%) нь “Хэрэгжих шатанд”, 8(11.8%) нь “Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй”-гээр тус тус дүгнэж, биелэлт (дунджаар)-ийг 94.2 хувиар үнэлж Дотоод аудит, мониторингийн газрын даргын 2026 оны 02/122 дугаар албан бичгээр Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэв
5.2	Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн хэрэгжилт, салбарын дотоод үйл ажиллагаа, сангийн болон байгууллагын санхүү, үйл ажиллагаанд аудит хийх, хяналт тавих, дүгнэлт, зөвлөмж гаргах;	-	Хийсэн аудит, хяналт шалгалтын тайлангийн тоо;	7	8	1.Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны А/05, А/62 дугаар тушаалаар баталсан удирдамжийн дагуу Хан-уул дүүргийн Нийгмийн даатгалын газрын 2023 оны 07-12 дугаар сар, 2024, 2025 он, Налайх дүүргийн Нийгмийн даатгалын газарт 2023-2025 оныг хамруулан санхүү, үйл ажиллагааны зардлын зарцуулалтыг анхан шатны баримттай тулган шалгав. Шалгалтаар илэрсэн зөрчилд нийт 76.8 сая төгрөгийн 13 акт, 70.5 сая төгрөгийн 13 зөрчилд 10 албан шаардлага, 12.3 сая төгрөгийн 9 зөрчилд 2 зөвлөмж хүргүүлэв. Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын газарт хийсэн хяналт шалгалтын дүн мэдээг Газрын даргын зөвлөлд 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдөр, Налайх дүүрэг, Орхон аймгийн Нийгмийн даатгалын газарт хийсэн хяналт шалгалтын дүн мэдээг 2026 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн хуралд танилцуулав. Мөн Архангай аймгийн Нийгмийн даатгалын газрын албан хаагчаас ирүүлсэн өргөдлийн дагуу тус газрын 2025 оны 7-12 дугаар сард олгосон орон нутгийн нэмэгдлийг харилцахын хуулга, цалингийн тооцооны хүснэгт зэрэг баримтад тулган шалгав. Шалгалтаар илэрсэн зөрчилд 1 зөвлөмж хүргүүлэв. Шалгалтаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар нэгтгэж, дүн мэдээг танилцуулна Мөн Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын газарт төлөвлөгөөт хяналт шалгалт хийгдэж байна.

5.3	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих, хяналт-шинжилгээ хийх, дүгнэлт, зөвлөмж гаргах;		Хяналт-шинжилгээний тайлангийн тоо;	9	10	Нийгмийн даатгалын ерөнхий газар, Мэдээллийн технологийн төв, БНСУ дахь ХНХҮ-ний төвийн Нийгмийн даатгалын тасаг, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын байгууллагын үйл ажиллагааны болон нийгмийн даатгалын сангийн мэдээллийг шилэн дансны цахим хуудас (shilendans.gov.mn)-т хуулийн хугацаанд үнэн зөв, бодитой мэдээлсэн эсэхэд 2026 оны 1 дүгээр улирлын байдлаар хяналт-шинжилгээ хийж холбогдох баримт бичигтэй тулган шалгав. Хяналт шинжилгээгээр байгууллагын үйл ажиллагаа болон нийгмийн даатгалын сангийн нийт 2 119.1 тэрбум төгрөгийн зөрчил илэрснээс: - 8 617.0 тэрбум төгрөгийн 164 шийдвэр гүйлгээг мэдээлээгүй; - 8 073.0 тэрбум төгрөгийн 130 шийдвэр гүйлгээг илүү мэдээлсэн; - 2 103.7 тэрбум төгрөгийн 4 208 шийдвэр гүйлгээг хугацаа хоцроож мэдээлсэн ба хяналт шинжилгээний явцад зөрчлийг залруулж нөхөн мэдээлсэн 198.5 тэрбум төгрөгийн 95 шийдвэр гүйлгээ мэдээлэл байна. 2. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам”-ын 8.1-т зааснаар Нийгмийн даатгалын харьяа байгууллагуудын 2025 оны жилийн эцэс, 2026 оны 1 дүгээр улирлын байдлаарх шилэн дансны хөтлөлтийн тайланг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэлд үндэслэн хяналт тавьж нэгтгэлийг гаргаж Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2025 оны “Шилэн дансны тухай хууль болон холбогдох журмыг хэрэгжүүлж ажиллах тухай” 03 дугаар албан даалгаврын биелэлт, шилэн дансны хөтлөлтийн 2025 оны 04 дүгээр улирлын тайланг Дотоод аудит, мониторингийн газрын даргын 02/95 дугаар албан бичгээр, 2026 оны 1 дүгээр улирлын тайланг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны 01/432 дугаар албан бичгээр тус тус Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яаманд хүргүүлэв
			Хугацаанд нь хүргүүлсэн байдал;	9	10	
			Нэгжүүдэд хүргүүлсэн зөвлөмжийн тоо;	2	2	

						3.Шилэн дансны тухай хууль холбогдох журмын хэрэгжилтэд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийг арилгах, цаашид давтан гаргахгүй байх, дотоод хяналтыг сайжруулж үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах талаарх зөвлөмжийг Дотоод аудит, мониторингийн газрын даргын 2026 оны “Шилэн дансны цахим хуудаст мэдээлэл байршуулахтай холбоотой зөвлөмж хүргүүлэх тухай” 01/432 дугаар албан бичгээр Мэдээллийн технологийн төв, БНСУ дахь Нийгмийн даатгалын тасгийн дарга, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нарт хүргүүлэв 3.Нийгмийн даатгалын байгууллагын мэдээллийн ил тод нээлттэй байдалд 2026 оны 1 дүгээр улирлын байдлаар хийсэн хяналт-шинжилгээгээр салбарын хэмжээнд байгууллагын цахим хуудасны мэдээлэл нийтэлж байршуулсан байдал Нийгмийн даатгалын ерөнхий газар 77.8 хувь, салбарын хэмжээнд 87.6 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнд: - Чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын мэдээллийн ил, тод нээлттэй байдал 88.9 хувь; - Хүний нөөц талаар мэдээллийн ил, тод нээлттэй байдал 89.9 хувь; - Төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны мэдээллийн ил, тод нээлттэй байдал 87.6 хувь; - Үзүүлж байгаа үйлчилгээний талаарх мэдээллийн ил, тод нээлттэй байдал 88.0 хувь; - Бусад мэдээллийн ил, тод нээлттэй байдал 80.0 хувьтай байна. Мэдээлэл байршуулах үйл ажиллагааг сайжруулж, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах талаарх зөвлөмжийг аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нарт хүргүүлэхээр бэлтгэж байна.
5.4	Төрийн захиргааны төв байгууллага болон хяналт шалгалтын бусад байгууллагаас		Хяналт-шинжилгээ хийсэн тайлангийн тоо;	4	5	Үндэсний аудитын газраас нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллага, Нийгмийн даатгалын сангийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нэгтгэв.

	хийсэн хяналт шалгалт, санхүүгийн тайлангаар өгөгдсөн шийдвэрийн хэрэгжилтийг хангуулах;		Хугацаанд нь хүргүүлсэн байдал	4	5	Санхүүгийн тайлангийн аудитаар салбарын хэмжээнд нийт 173 468 329 сая төгрөгийн төлбөр, зөрчил илэрснээс: - Санхүүгийн тайланд 493 157 сая төгрөгийн залруулга; - 17 404 сая төгрөгийн 14 акт; - 158 843 882 сая төгрөгийн 32 албан шаардлага; - 10 929 685 сая төгрөгийн 72 зөвлөмж өгөгдсөн. Байгууллагын болон нийгмийн даатгалын сангийн 2025оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүнгийн нэгтгэлээр 22 тайланг түүврээр шалгасан бөгөөд бусад тайланд дараах дүгнэлт өгөгдсөн байна. Үүнд: - Өөрчлөлтгүй 42; - Хязгаарлалттай 2; Санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор нэгтгэнэ.
З о р						
6.1	Нийгмийн даатгалын багц хуулиуд, Зөрчлийн тухай хууль болон холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтийг батлагдсан удирдамжийн дагуу 6 аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газарт шалгаж, өмнөх шалгалтын үр дүнг тооцож, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх;	52,8 сая төг	Хяналт шалгалтын тоо	6	6	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу Хан-Уул, Налайх дүүрэг, Орхон аймгийн Нийгмийн даатгалын газарт Нийгмийн даатгалын багц хууль тогтоомжийн хэрэгжилтийг болон өмнөх шалгалтын мөрөөр зохион байгуулж, хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэл, үр дүнд төлөвлөгөөт хяналт, шалгалт хийж илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулж, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж ажиллав.
			Улсын байцаагчийн акт, төлбөрийн барагдуулалтын хувь	71,8 %	72%	Дээрх 3 аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газарт нийгмийн даатгалын сангийн хөрөнгийн 2019-2024 оны зарцуулалтыг анхан шатны баримттай тулган шалгаж ердийн болон хөнгөлөлттэй нөхцөлөөр өндөр насны тэтгэвэр шинээр тогтоосон нийт 15,910 тэтгэврийн тогтоолт, олголт болон анхан шатны баримтын үндэслэлийг, давхардсан тоогоор нийт 171,237 тэтгэвэр

						авагчийн тэтгэврийн олголтыг нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн сангийн өгөгдөлд тулгуурлан шалгав. Ажилгүйдлийн даатгалын сангаас 2019-2025 онд 1,385 даатгуулагчид олгосон ажилгүйдлийн тэтгэмж, тэтгэмжийн даатгалын сангаас 6,148 даатгуулагчид олгосон жирэмсний болон амаржсаны, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийн үндэслэлийг анхан шатны баримт болон мэдээллийн нэгдсэн сангийн өгөгдөлд тулгуурлан шалгав. Шалгалтаар нийт 249 хүнтэй холбоотой 1,258.2 сая төгрөгийн төлбөр, зөрчил илрүүлж улсын ахлах байцаагчийн 15 ширхэг акт тогтоож шийдвэрлэв. Үүнд: 1.Тэтгэврийн олголттой холбоотой 61 хүнд илүү олгосон тэтгэврийн зөрүү 315.9 сая төгрөг, дутуу олгосон 21 хүнд 23.8 сая төгрөгийн тэтгэвэр, 14 хүнд 8.3 сая төгрөгийн тэтгэмж, төлбөрийг илүү авсан иргэнээр нөхөн төлүүлэх, дутуу олгосон тэтгэврийг нөхөн олгуулах улсын байцаагчийн акт тогтоов. 2.Тэтгэврийн тогтоолттой холбоотой нэр бүхий 89 хүний тэтгэврийн дутуу бүрдүүлсэн баримтыг нөхөн бүрдүүлэх хүртэл тэтгэврийг түр түдгэлзүүлэх; 3.Хуурамч баримт бүрдүүлэн хөнгөлөлттэй нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгосон 31 хүний тэтгэврийн олголтыг зогсоож, тэтгэврийн даатгалын санд 884.6 сая төгрөгийг нөхөн төлүүлэх улсын байцаагчийн актыг тус тус тогтоов. Шалгалтаар илэрсэн зөрчил, төлбөрийн биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 30-ний өдрийн дотор нэгтгэхээр бэлтгэж байна.
6.2	Нийгмийн даатгалын багц хууль, тогтоомжийн хэрэгжилтийг аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг шалгаж, үр дүнг тооцож ажиллах;		-Шалгасан ААНБ-ын тоо	348	400	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн баталсан 02 дугаар "Аж ахуйн нэгж, байгууллагад нийгмийн даатгалын багц хууль тогтоомжийн хэрэгжилтийг шалгах нэгдсэн удирдамж"-ийн дагуу 2026 онд шалгалтад хамруулах аж ахуйн нэгж, байгууллагыг нийгмийн даатгалын шимтгэлийн хуримтлагдсан өр, Хувь хүний орлогын албан татварын тайлангийн цалин хөлсний сан болон нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлангийн зөрүү, гадаад улсын иргэн ажиллуулсан байдал, хуульд

						заасан хугацаанд нийгмийн даатгалын байгууллагад бүртгүүлээгүй зэрэг эрсдэлийн шалгуур үзүүлэлтээр үнэлж сонгон шалгасан. Үүний дагуу 2026 оны 1 дүгээр улиралд хуримтлагдсан хамгийн өндөр өртэй ажил олгогчдыг шалгалтад хамруулж 1,238 аж ахуйн нэгж, байгууллага шалгаж 3.0 тэрбум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэл, түүнд ногдох 1.2 тэрбум төгрөгийн алданги, төлбөрийн зөрчил илрүүлж ажилласан.
			Илрүүлсэн зөрчлийн дүн	1639,2 сая төгрөг	-	Хяналт шалгалтын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг нэгтгэн нийт 4.2 тэрбум төгрөгийг төлбөр зөрчлийг барагдуулсан. Харин Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 115 дугаар тогтоолоор 2026 оны төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг цуцалсан болно.
6.3	Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн дагуу нийгмийн даатгалын сангийн орлогыг бүрдүүлэх, шимтгэлийн авлага барагдуулах ажлыг зохион байгуулах;		НДШ-ийн орлогын төлөвлөгөөний биелэлт	5,232,8 тэрбум тэгрэг	7,824.7 тэрбум төгрөг	Нийгмийн даатгалын сангийн 2026 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу 2026 оны эхний хагас жилд улсын төсвийн татаас 890.2 тэрбум төгрөг, бусад төр хариуцах иргэдийн шимтгэл 26.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг сар, улирлын хуваарийн дагуу 100 хувь санд төвлөрүүлсэн. Түрээсийн орлого болон харилцах, хадгаламжийн хүүгийн орлогоор 72.8 тэрбум төгрөгийн орлогыг бүрдүүлж, сар бүр баталгаажуулсан. Нийгмийн даатгалын сангийн 2026 оны Төсвийн тухай хуулиар ажил олгогч, даатгуулагчаас төлөх шимтгэлийн орлогын төлөвлөгөөг 6.2 их наяд төгрөгөөр баталсан бөгөөд эхний 5 сарын байдлаар орлогын төлөвлөгөө 102.5 хувьтай байна. Оны эхнээс орлогын төлөвлөгөөг: - 01 дүгээр сард 385.9 тэрбум.төг оруулж төлөвлөгөөг 100.2 хувиар; - 02 дугаар сард 831.0 тэрбум.төг оруулж төлөвлөгөөг 105.6 хувиар; - 03 дугаар сард 1,380.8 тэрбум.төг оруулж төлөвлөгөөг 108.4 хувиар;

						- 04 дугаар сард 1,873.2 тэрбум.төг оруулж төлөвлөгөөг 106.0 хувиар; - 05 дугаар сард 2,350.8 тэрбум.төг оруулж төлөвлөгөөг 102.7 хувиар буюу сар бүр жигд ханган биелүүлж байна. Энэхүү ажлын хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулан ажилласан.Үүнд: - Орлогын төлөвлөгөөний биелэлт 63.5 хувийн үзүүлэлттэй байгаа Солонгос улсад ажиллаж амьдарч байгаа хөдөлмөрийн насны иргэдийг нийгмийн даатгалд бүрэн хамруулах, шимтгэлийн орлогын төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, нийгмийн даатгалын ач холбогдлыг сурталчлан таниулах сургалт зохион байгуулж, хамралтыг нэмэгдүүлэх тухай чиглэлийг Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны “Орлогын төлөвлөгөөний тухай” 01/1021 дугаар албан бичгээр Солонгос улс дахь Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын үйлчилгээний төвд хүргүүлсэн. - Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг 6-12 сард орлогын төлөвлөгөөг жигд биелүүлэх тухай үүрэг даалгаврыг Хяналт шалгалтын газрын 2026 оны “Ажил эрчимжүүлэх тухай” 07/1629 дугаартай албан бичгээр Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудад хүргүүлэв. - Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөний биелэлтэд тогтмол хяналт тавих чиглэлээр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, цахим хурлыг 3 удаа зохион байгуулав.
			НДШ-ийн авлага барагдуулалт	697,0 тэрбум төгрөг	592,4 тэрбум төгрөг	2025 оны жилийн эцэст 697.6 тэрбум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн өр үүссэнээс 2026 оны 05 дугаар сарын байдлаар 361.7 тэрбум төгрөгийн хуримтлагдсан өрийг төлүүлж, авлагыг 51.5 хувиар бууруулсан боловч авлага 5 дугаар сарын эцэст 675.0 тэрбум төгрөгт хүрч, оны эхний авлагаас 22.6 тэрбум төгрөгөөр буюу 3.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Төв, орон нутгийн Нийгмийн даатгалын байгууллагуудаас сар бүрийн 01, 15-ны өдрүүдэд өр барагдуулах талаар хийж хэрэгжүүлсэн ажлын мэдээг

					тогтмол авч нэгтгэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/199 дүгээр тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, нөхөн төлүүлэх журам”-ын дагуу нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг бууруулах ажлын хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулж, хуримтлагдсан 113.6 тэрбум төгрөгийн авлагыг барагдуулсан.Үүнд Нийгмийн даатгалын шимтгэлийн 132.0 тэрбум төгрөгийн өртэй 110 ажил олгогчид улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж 37.7 тэрбум төгрөгийн; Шимтгэлийн 163.1 тэрбум төгрөгийн өртэй 6768 ажил олгогчийн харилцах банкн дахь дансыг хааснаар 18.7 тэрбум төгрөгийн; Нийт 68.5 тэрбум төгрөгийн өртэй 602 ажил олгогчтой өр авлага барагдуулах гэрээ байгуулсанаар 23.3 тэрбум төгрөгийн; Шимтгэлийн 136.9 тэрбум төгрөгийн өр үүсгэсэн 1203 ажил олгогчийн удирдагатай уулзалт зохион байгуулж 31.9 тэрбум төгрөгийн; Шимтгэлийн хуримтлагдсан өртэй 156 ажил олгогчийн 36.6 тэрбум төгрөгийн өрийг төлүүлэхээр шүүхэд нэхэмжилсэнээр 352.5 сая төгрөгийн; Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын ажиллагаанд байгаа шимтгэлийн өртэй 352 аж ахуйн нэгж, байгууллагын 74.0 тэрбум төгрөг өрнөөс эхний хагас жилийн байдлаар 4.4 тэрбум төгрөгийн шимтгэл, 772.8 сая төгрөгийн алдангийг тус тус төлүүлээд байна. Мөн шимтгэлийн өрийг барадуулахад хамтран ажиллах хүсэлтийг Эрүүл мэндийн, Сангийн, Боловсролын, Гэр бүл хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд, Үндэсний Аудитын ерөнхий газар, Аймаг, дүүргийн Засаг дарга, Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын, Эрүүл мэндийн даатгалын ерөнхий, Боловсролын ерөнхий, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх, Нийслэлийн Эрүүл мэндийн, Нийслэлийн Боловсролын газруудад тус тус хүргүүлэн ажилласан.
--	--	--	--	--	--

6.4	Төлөвлөгөөт шалгалтын хүрээнд аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газарт ажиллах явцад нийгмийн даатгалын хамрах хүрээг нэмэгдүүлэх, 180 буюу түүнээс дээш хоногийн насжилттай хуримтлагдсан өрийг барагдуулах ажлыг зохион байгуулах;		ААНБ-ын тоо	180	180	Төлөвлөгөөт хяналт шалгалтыг Хан-Уул, Налайх дүүргийн Нийгмийн даатгалын газар болон Орхон аймгийн Нийгмийн даатгалын газарт хийж 2 удаа зөвлөгөөн зохион байгуулж сайн дурын даатгуулагчийн хамралтыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж ажилласан. Шалгалтын хугацаанд нийгмийн даатгалын шимтгэлийн 180 буюу түүнээс дээш хоногийн насжилттай хуримтлагдсан өр барагдуулах ажлыг зохион байгуулж Хан-Уул, Налайх дүүргийн 67 ажил олгогчтой уулзаж, уулзалтын тэмдэглэл хөтөлж, данс хааж, шүүхэд шилжүүлэх ажлыг зохион байгуулав. Орхон аймгийн 28 ажил олгогчийн захирал, нягтлан бодогчтой уулзалт зохион байгуулж шимтгэлийн хуримтлагдсан өрийг барагдуулан ажилласан.
			НДШ-ийн хуримтлагдсан авлагыг барагдуулсан дүн	3292,3 сая төгрөг	1% нэмэгдүүлнэ	Төлөвлөгөөт хяналт шалгалтын хугацаанд нийт 769 ажил олгогчийн 12.9 тэрбум төгрөгийн хуримтлагдсан өрийг барагдуулан ажиллав. Үүнд: - Хан-Уул дүүргийн 237 ажил олгогчийн 8 958,7 сая төгрөгийн өр; - Налайх дүүргийн 268 ажил олгогчийн 1 452.9 сая төгрөгийн өр; - Орхон аймгийн 228 ажил олгогчийн 2 577.6 сая төгрөгийн өрийг тус тус барагдуулав.
6.5	Нийгмийн хамгааллын салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн объектод төлөвлөгөөт шалгалт хийх, мэдээ тайланг нэгтгэх;		Шалгах объект	351	501	Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 4 дүгээр сарын 08-ны өдрийн “Салбарын хяналт шалгалтын талаар авах арга хэмжээний тухай” 115 дугаар тогтоолоор Засгийн газрын 2025 оны 184 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Салбарын хяналт шалгалтын 2026 оны төлөвлөгөө"-ний холбогдох заалтыг хүчингүй болгосонтой холбоотойгоор нийгмийн хамгааллын салбарын хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн объектод хийх төлөвлөгөөт хяналт шалгалт цуцлагдсан.
			- Гүйцэтгэлийн хувь,	85,5%	90,5%	
6.6	Нийгмийн Халамжийн сангийн 2023-2025 оны санхүүгийн болон бусад баримт, мэдээлэлд		Илэрсэн зөрчил арилгалтын хувь,	-	70%	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2026 оны 05 дугаар сарын 05-ны өдрийн “Төлөвлөгөөт бус хяналт шалгалт зохион байгуулах тухай” А/87 дугаар тушаал, Салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 2026 оны “Төлөвлөгөөт бус шалгалт хийх тухай” 05-07/28 дугаар “Хяналт шалгалтын удирдамж”-

	тулгуурлан Хөгжлийн бэрхшээлтэй иргэний тэтгэвэр тогтоолт, олголт, асаргааны тэтгэмж, амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмжийн тогтоолт, олголт, протез, ортопед, тусгай хэрэгслийн нийлүүлэлт, олголт, ахмадын амралт, сувилал, магадлан итгэмжлэгдсэн рашаан, сувилалын үйл ажиллагаа, холбогдох хууль тогтоомж, стандартын хэрэгжилтэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хийх;		Хууль сахин мөрдөлтийн түвшин (хувиар)	-	70%	ийн дагуу Хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээний ерөнхий газар түүний аймаг, дүүрэг дэх харьяа 29 газарт төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг зохион байгуулан ажиллаж байна. Шалгалтад Хэнтий аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газарт нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагчгүй тул хяналт шалгалт хийгдээгүй. Хяналт шалгалтыг 2026 оны 06 дугаар сарын 10-ыг дуустал хугацаанд зохион байгуулах бөгөөд 2026 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн байдлаарх явцын мэдээллийг нэгтгэхэд нийт 29 халамжийн байгууллагын 121,211 иргэнд үзүүлсэн халамжийн үйлчилгээнүүдийг шалгахад нийт 923 иргэн, албан тушаалтанд хамаарах 329.7 сая төгрөгийн зөрчлийг илрүүлж, хяналт шалгалтын явцад нийт 82.2 сая төгрөгийн зөрчил буюу 32.5 хувийн зөрчлийг арилгуулж, 1,519 иргэн, албан тушаалтанд хамаарах 247.5 сая төгрөгийн зөрчилд 63 улсын байцаагчийн актаар нөхөн төлбөр тооцон, 51 заалт бүхий 19 улсын байцаагчийн албан шаардлага тус тус хүргүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.
Стратегийн төлөвлөгөөний зорилго 3: Нийгмийн даатгалын үйлчилгээ, мэдээллийн нэгдсэн санг боловсронгуй болгож, дэвшилтэт шинэ технологи нэвтрүүлэх, олон нийтэд мэдээлэх, сурталчлах;						
3						
о						
7.1	Нийгмийн даатгалын мэдээллийн шинэ системийн хэрэглээг сайжруулах зорилгоор иргэд, даатгуулагч, ажил олгогчоос сэтгэл ханамжийн судалгаа авч нэгтгэн дүгнэх, сайжруулах санал боловсруулж, хэрэгжүүлэх;		Зохион байгуулсан судалгааны тоо	-	4	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны А/76 дугаар тушаалаар баталсан удирдамжийн дагуу Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын газарт, 2026 оны 03 дугаар сарын 27-ны өдрөөс 04 дүгээр сарын 10-ны өдрийн өдрүүдэд, мөн Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны А/119 дугаар тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын газарт 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрөөс 05 дугаар сарын 11-ний өдрийг дуусталх хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний чанар, стандартын хэрэгжилтэд хяналт тавьж, цаашид ажил сайжруулах талаар зөвлөгөө, зааварчилгаа өгч ажиллав.

						Ажлын тайлан, үр дүнг Газрын даргын зөвлөлийн хуралд танилцуулж ажил сайжруулах, үүрэг даалгавар өгөх тухай чиглэлийг Захиргаа удирдлагын газрын даргын 2026 оны 3/1663 дугаар албан бичгээр Хан-Уул, Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын газруудад хүргүүлсэн
			Оролцогчийн тоо	-	Ажил олгогч-6,000 Иргэд даатгуулагч-1800	Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газрууд нь /21 аймаг, 9 дүүрэг/ 2026 оны эхний хагас жилийн байдлаар мэдээллийн шинэ системийн хэрэглээг сайжруулах зорилгоор иргэд, даатгуулагч, ажил олгогчдоос авсан сэтгэл ханамжийн судалгаанд 2,749 ажил олгогч, 5,285 иргэд, даатгуулагчид хамрагдсан. Үүнээс:Portal.ndaatgal.mn цахим хуудсаар 487 ажил олгогч, 899 иргэд, даатгуулагч нийт 3,236 ажил олгогч, 6,184 иргэд, даатгуулагчид хамрагдсан байна.
7.2	Нийгмийн даатгалын үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой иргэдийн сэтгэл ханамжийн судалгаа авч дүгнэх, сайжруулах санал боловсруулж, хэрэгжүүлэх;		Зохион байгуулсан судалгааны тоо	6	2	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны А/76 дугаар тушаалаар баталсан удирдамжийн дагуу Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын газарт, 2026 оны 03 дугаар сарын 27-ны өдрөөс 04 дүгээр сарын 10-ны өдрийн өдрүүдэд, мөн Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2026 оны А/119 дугаар тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын газарт 2026 оны 04 дүгээр сарын 29-ний өдрөөс 05 дугаар сарын 11-ний өдрийг дуусталх хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний чанар, стандартын хэрэгжилтэд хяналт тавьж, цаашид ажил сайжруулах талаар зөвлөгөө, зааварчилгаа өгч ажиллав. Ажлын тайлан, үр дүнг Газрын даргын зөвлөлийн хуралд танилцуулж ажил сайжруулах, үүрэг даалгавар өгөх тухай чиглэлийг Захиргаа удирдлагын газрын даргын 2026 оны 3/1663 дугаар албан бичгээр Хан-Уул, Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын газруудад хүргүүлсэн
			Оролцогчийн тоо	1257	2040	Нийгмийн даатгалын үйл ажиллагаа, үйлчилгээтэй холбоотой иргэдийн сэтгэл ханамжийн судалгаанд 21 аймаг, 9 дүүргийн нийт 3,045 ажил олгогч, 7,452 иргэд, даатгуулагчид хамрагдсан байна.
7.3	Иргэд, даатгуулагчдад утсаар (CallPro)		Дуудлага алдалтын хувь	Аймаг-12.4%,	Аймаг-10%, Дүүрэг-15%	Нийгмийн даатгалын салбарын хэмжээнд иргэд, даатгуулагчдад утсаар (CallPro) мэдээлэл зөвлөгөө өгөх үйлчилгээг үзүүлж, “КоллПро” ХХК-ний

	мэдээлэл зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулах, сайжруулах, хөгжүүлэх;			Дүүрэг-26.9%		console.callpro.mn веб программаас улирал бүр тайлан мэдээг авч нэгтгэн хяналт тавин ажиллаж байна. Тайлант хугацаанд аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газарт ирсэн нийт 288.418 дуудлага ирснээс 235.227 хүлээн авсан ба дуудлагын алдалтын хувь 18.4 хувьтай байна. Дуудлага алдалтын дундаж хувь: - Аймагт 14.1 хувь; - Дүүрэгт 18.6 хувьтай байна
7.4	Нийгмийн даатгалын сангаас олгох зарим төрлийн тэтгэврийг цахимаар хүсэлт гаргах боломжийг бүрдүүлэх;	-	Үйлчилгээний тоо	2	4	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан 2025 оны “Хөтөлбөр батлах тухай” А/138 дугаар тушаалаар “Цахим шилжилт, их өгөгдөлд суурилсан нийгмийн даатгалын үйлчилгээний дунд хугацааны хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд зарим төрлийн тэтгэвэр түүний дотор олон хүүхэдтэй эхийн нөхцөлөөр тогтоох өндөр нас, энгийн өндөр нас, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэврийг иргэнээс баримт бичиг шаардахгүйгээр цахимжуулахаар тусгасан. Тайлант онд нийгмийн даатгалын сангаас олгох энгийн өндөр насны, олон хүүхэдтэй эхийн нөхцөлөөр тогтоолгох өндөр насны, тэжээгчээ алдсаны, цэргийн алба хаасны гэсэн 4 төрлийн тэтгэврийг цахимаар хүсэлт гаргах боломжийг бүрдүүлж цахимжуулахаар зорилтын хүрээнд эхний хагас жилийн байдлаар энгийн өндөр нас, олон хүүхэдтэй эхийн нөхцөлөөр өндөр насны тэтгэврийн эрх үүсэх иргэдийн тэтгэвэр тогтоолгох хүсэлтийг цахимаар хүлээн авах программын даалгаврыг боловсруулж Мэдээллийн технологийн төвд хүргүүлсэн. Энэ ажлын хүрээнд нийгмийн даатгалын сангаас олгох өндөр насны тэтгэвэр болон хүүхдийн нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгох иргэн хүсэлтээ цахимаар гаргах боломжийг бүрдүүлэх Portal.ndaatgal.mn системийн хөгжүүлэлт хийгдэж, ажлын явц 40 хувьтай байна. Энэхүү хөгжүүлэлтийн хүрээнд дараах ажлууд хийгдэж байна. Үүнд: - Иргэний тэтгэвэр тогтоолгох хүсэлтийг цахимаар бүртгэх;

						- Шаардлагатай баримт бичгийг цахимаар хавсаргах; - Иргэн хүсэлтийн явцыг цахимаар хянах; Тэтгэвэр тогтоолгох хүсэлтийн үйлчилгээг цахимжуулснаар нийгмийн даатгалын цахим үйлчилгээний хүрээ өргөжиж, иргэд, даатгуулагчдад үзүүлэх нийгмийн даатгалын үйлчилгээний хүртээмж, шуурхай байдал нэмэгдэх давуу талтай.
7.5	Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн хүсэлтийг цахимаар гаргах боломжийг бүрдүүлэх;	-	Үйлчилгээний тоо	5	5	Тэтгэмжийн болон ҮОМШӨ-ний даатгалын сангаас олгох нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж (энгийн болон донор) авах гэр бүлийн хүний хүсэлтийг иргэн Portal.ndaatgal.mn системийг ашиглан цахимаар гаргах үйлчилгээг хөгжүүлэн салбарын хэмжээнд шинээр нэвтрүүллээ. Ингэснээр иргэд нийгмийн даатгалын байгууллагад биечлэн ирэлгүйгээр, цаг хугацаа, орон зайнаас үл хамааран хүсэлтээ цахимаар түргэн шуурхай гаргаж, үйлчилгээ авах боломж бүрдсэн.
7.6	Нийгмийн даатгалын байгууллагын ажлын байр, үйлчилгээний орчны стандартыг мөрдөж байгаа эсэхэд хяналт тавих, үнэлгээ өгөх, өөрчлөлт оруулах;	-	Хяналт тавьж, үнэлгээ өгсөн аймаг, дүүргийн тоо	-	Аймаг-2, Дүүрэг-7	Тайлант хугацаанд Хан-Уул, Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын газарт байгууллагын үйл ажиллагаа, үйлчилгээний чанар, ажлын байр, үйлчилгээний орчны стандартыг мөрдөн хэрэгжүүлж байгаа эсэхэд хяналт тавьж, үр дүнг тооцон цаашид сайжруулах талаар зөвлөмж, чиглэл, заавар өгч ажиллав. Төсвийн хэмнэлтийн хүрээнд орон нутагт томилолтоор ажиллах боломжгүй тул сүүлийн хагас жилд хийхээр төлөвлөж байна.
7.7	Иргэд даатгуулагч, ажил олгогчдоос цахим хэлбэрээр ирүүлсэн асуулт, санал шүүмж, хүсэлт, гомдол, талархалд дүн шинжилгээ хийх;		Цахимаар ирүүлсэн асуулт, санал шүүмж, хүсэлт, гомдол, талархлын тоо	6510	3200	Нийгмийн даатгалын ерөнхий газар, 21 аймаг, 9 дүүргийн Нийгмийн даатгалын газарт хандаж 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 06 дугаар сарын 05-ны өдрийг дуустал хугацаанд ирүүлсэн нийт 1482, үүнээс: Sanal@ndaatgal.mn мэйл хаягаар 186, Засгийн газрын Иргэд олон нийттэй харилцах 11-11 төвд 1296 талархал, санал, хүсэлт, шүүмж, өргөдөл, гомдлын тоон мэдээ, судалгааг нэгтгэн өргөдөл, гомдлын, шийдвэрлэлтэд дүн-шинжилгээ хийв
			Дүн шинжилгээ хийж тайлагнасан тоо	2	2	Нийт нэгтгэлээс харахад ирүүлсэн талархал, санал, хүсэлт, гомдлын хамгийн их буюу 67.6 хувь нь ажилгүйдлийн тэтгэмж, 10.16 хувь нь хөдөлмөрийн

						чадвар түр алдсаны, 8.97 хувь нь жирэмсний болон амаржсаны тэтгэмжтэй холбоотой байна.
7.8	Хиймэл оюун ухаанд суурилсан чатбот үйлчилгээг нэвтрүүлэх;	-	Хэрэгжүүлсэн ажил	-	1	Хиймэл оюун ухаанд суурилсан чатбот үйлчилгээг нэвтрүүлэх ажлын хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий газрын FACEBOOK хуудасны чатбот үйлчилгээг ndaatgal.mn вэб хуудастай холбож, иргэд, даатгуулагчдаас түгээмэл ирүүлдэг асуултад автомат сонголтоор хариулт авах боломжийг бүрдүүлсэн. Энэ нь 24/7 цагийн турш иргэд, даатгуулагчид тэтгэвэр, тэтгэмж, ажилгүйдэл, үөмшө, сайн дурын даатгал зэрэг сонголтуудаас өөрийн хэрэгцээт асуултаа сонгон тэтгэмж авах эрх хэрхэн үүсэх, олгох хугацаа, тэтгэмж бодолтын мэдээлэл гэх мэт хариултыг авах боломжтой болсон. Мөн Хиймэл оюун ухаанд суурилсан чатбот үйлчилгээнд хэрэглэгдэх дотооддоо болон гадагшаа чиглэсэн мэдээллийн сан бэлтгэв. Үүнд: - Дотогшоо чиглэсэн үйлчилгээнд хэрэглэгдэх мэдээллийн сан бүрдүүлэх зорилгоор нийгмийн даатгалын хууль тогтоомжийн хүрээнд журам, зааврыг холбогдох газруудаас авч бэлтгэв. - Гадагшаа чиглэсэн үйлчилгээнд зориулсан 168 асуулт, хариултын санг холбогдох газруудтай хамтран боловсруулав. Түүнчлэн КоллПро ХХК-тай хамтран “CallPro AI” хиймэл оюунд суурилсан ухаалаг харилцаа буюу дуудлагын төвийн ярианы бичлэгийг текст рүү хөрвүүлэх, анализ хийх, тухайлсан түлхүүр үгээр хайлт хийх болон автомат хариулагчгүйгээр шаардлагатай мэдээллийг өгөх зэрэг үйлчилгээг хэрэгжүүлэх боломжтой эсэх талаар 2 удаагийн уулзалт зохион байгуулав. КоллПро ХХК-тай хамтран “CallPro AI” хиймэл оюунд суурилсан ухаалаг харилцааг хэрэгжүүлэх тохиолдолд бэлтгэл ажлыг хангах үүднээс CallPro Voice дуудлагын утсанд голчлон ямар асуудлаар холбогдож байгааг аймаг, дүүргийн нийгмийн даатгалын газруудаас судалгаа авч мэдээллийн сан үүсгэхээр ажиллаж байна.

7.9	Нийгмийн даатгалын хууль тогтоомж, ач холбогдол, үйл ажиллагаа, үйлчилгээг иргэд, даатгуулагчдад ойлгомжтой, шинэлэг байдлаар тайлбарласан контент хүргэх;	-	Мэдээлэл бэлтгэсэн тоо	681	400	Тайлант хугацаанд Нийгмийн даатгалын хууль тогтоомж, ач холбогдол, үйл ажиллагаа, үйлчилгээг иргэд, даатгуулагчдад ойлгомжтой, шинэлэг байдлаар тайлбарласан мэдээ мэдээлэл, постер, рийл, контент 1,576 бэлтгэсэн хүргэсэн байна.
			Хандалтын тоо	81 000 000	100 000 000	2026 оны эхний хагас жилийн байдлаар хандалтын тоо 51 596 000-д хүрсэн байна.
			Дагагчдын тоо	177 000	187 000	Тайлант хугацаанд дагагчдын тоо 185 000 хүрч өмнөх оныхоос 8 000 дагагчаар өссөн байна.
7.10	Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлах чиглэлээр төрийн болон олон нийтийн байгууллага, хувийн хэвшил, төрийн бус байгууллагатай хамтран ажиллах;		Хамтран ажилласан байгууллагын тоо	24	15	Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлах чиглэлээр 19 сайт, 2 өдөр тутмын сонин, 1 телевиз, 1 мониторингийн үйлчилгээ үзүүлэх байгууллага зэрэг нийт 17 хувийн хэвшил, 6 олон нийтийн байгууллага, төрийн бус байгууллага буюу бүгд 23 байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулж, нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчлав. Мөн 10 телевиз, 2 сонин, 15 сайт зэрэг 27 /давхардсан тоогоор/ хэвлэл мэдээллийн байгууллагаар дамжуулан 240 /давхардсан тоогоор/ удаагийн давтамжтайгаар нийгмийн даатгалын хууль тогтоомж, үйл ажиллагаа, үйлчилгээний талаарх мэдээллийг иргэд даатгуулагчдад хүргэж, хэвлэл мэдээллийн байгууллагыг шаардлагатай 15 удаагийн эх сурвалжаар ханган ажилласан.Үүнд: zarig.mn, zindaa.mn, tovch.mn, mass.mn, news.mn, gogo.mn, medee.mn, gerelmedia.mn, time.mn, eguur.mn, suvd.mn, mnb.mn, itoim.mn, subeedei.mn, Өнөөдөр сонин, Зууны мэдээ, Mongol HD, Тэнгэр тв, TV-9, UBS, ETV, MM Агентлаг, C1, MN25, Eagle TV зэрэг болно.
			Хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлийн хувь	100%	100%	
7.11	Нийгмийн даатгалын байгууллагын үзүүлсэн үйлчилгээ, орлого, зарлагыг мэдээлэх “Мэдээллийн цаг”-тай болох;		Мэдээллийн тоо	-	5	Нийгмийн даатгалын байгууллагаас үзүүлсэн нийгмийн даатгалын үйлчилгээ, нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны талаарх тоон мэдээллийг иргэд, даатгуулагч, ажил олгогчидод хэвлэл, мэдээллийн хэрэгслээр дамжуулан хүргэх, сурталчлан таниулах, нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах зорилгоор “Мэдээллийн цаг”-ийг зохион байгуулах ажлын удирдамжийг боловсруулсан. Удирдамжид зааснаар мэдээллийн цагаар тухайн тайлант хугацаанд нийгмийн даатгалын салбарын хэмжээнд үзүүлсэн үйлчилгээний тоон мэдээллийг 8

						үзүүлэлтээр гаргаж мМэдээллийг сар бүрийн 10-12-ны өдөр зохион байгуулахаар заасан Мэдээллийн цаг хийхтэй холбоотойгоор тушаалын төсөл боловсруулж, хянуулахаар Газрын даргад хүргүүлсэн.
3 о						
8.1	Салбарын хэмжээнд хууль тогтоомжийн өөрчлөлт болон шинээр батлагдсан хуулийн хэрэгжилтийг хангах ажлыг мэдээллийн технологиор дэмжин ажиллах;		Хэрэгжилтийн хувь	100%	100%	Монгол улсын хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг хангах, тэдгээртэй холбоотой үйлчилгээ, үйл ажиллагааг мэдээллийн технологиор дэмжих хүрээнд мэдээллийн нэгдсэн систем болон иргэд, даатгуулагчдад зориулсан цахим системд нийт 50 гаруй удаагийн хөгжүүлэлт, өөрчлөлтийг хийж гүйцэтгэв. Тухайлбал: Монгол улсын Засгийн Газрын 2025 оны 242 тоот тогтоолын хэрэгжилтийн хангав. Засгийн газрын 2025 оны “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх, тэтгэврийн доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 242 тоот тогтоолын хэрэгжилтийг хангаж, нийт 524.9 мянган тэтгэвэр авагчийн тэтгэврийг 80.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэх, тэтгэврийн доод хэмжээг шинэчлэх ажлыг мэдээллийн нэгдсэн системээр шуурхай гүйцэтгэв. Ингэснээр Нийгмийн даатгалын сангаас болон Цэргийн тэтгэвэр авч буй 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр нэмэгдүүлсэн тэтгэврээ бүрэн авах боломжийг бүрдүүлсэн. Монгол улсын Засгийн Газрын 2025 оны 65 тоот тогтоолын хэрэгжилтийн хангав. Засгийн газрын 2025 оны Итгэлцүүр батлах тухай” 65 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, 2026 онд шинээр тэтгэвэр тогтоолгох иргэдийн дундаж цалин хөлс тооцоход ашиглах итгэлцүүрийг системд шинэчлэн орууллаа. Мөн тэтгэвэр тогтоох дундаж цалин хөлсийг шинэ итгэлцүүрээр өсгөн тооцсон цалинг харгалзах он тус бүрд мөрдөж байсан хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээгээр хязгаарлан тооцох боломжийг бүрдүүлсэн. Түүнчлэн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуулийн дагуу 2026 онд өндөр насны тэтгэвэр тогтоолгох иргэдийн

					- Шимтгэл төлсөн хугацааны шалгуурыг 22 жил 3 сараар шинэчлэх; -Дээрх хугацааны болзлыг хангаагүй тохиолдолд насны шалгуурыг эрэгтэй 62 нас 3 сар, эмэгтэй 57 нас 3 сар байхаар тооцох өөрчлөлтийг хийв; Ингэснээр 2026 оны эхний хагас жилд шинээр тэтгэвэр тогтоолгосон 9.1 мянган иргэний тооцооллыг цахимаар бүрэн хийж ажилласан байна. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 11 тоот тогтоолыг хэрэгжүүлэв. 1.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны “Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмжийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” 11 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд нийгмийн даатгалын сангаас олгож буй гэр бүлийн гишүүнд олгож буй тэтгэмжийн хэмжээг 3.0 сая, амьгүй донор болсон нас барагчийн хувьд 4.5 сая төгрөг болгон нэмэгдүүлэх хөгжүүлэлтийг програм хангамжид хийж нийт 6.0 мянган тэтгэмж авагчид үйлчилсэн байна. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны 12 тоот тогтоолыг хэрэгжүүлэв. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2025 оны “Сэргээн засах болон сувиллын тусламж үйлчилгээний төлбөрийн үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангаас олгох хэмжээг тогтоох тухай” 12 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх хүрээнд ҮОМШӨ-ийн даатгалын сангаас сувиллын зардал авагчийн нэг ор хоногийн зардлын хэмжээг 110.0 мянган төгрөг болгон нэмэгдүүлэх хөгжүүлэлтийг программ хангамжид оруулснаар нийт 509 даатгуулагчид энэхүү тарифаар тооцон олгосон байна. Шинээр 3 бүтээгдэхүүн хөгжүүлж нэвтрүүлэв. Нийгмийн даатгалын салбарын үйл ажиллагааг цахимжуулах, үйлчилгээний хүртээмж, үр ашиг, хяналтыг сайжруулах хүрээнд салбарын хэмжээнд ашиглагдаж буй SICOS мэдээллийн нэгдсэн систем болон иргэд, даатгуулагчдад зориулсан Portal.ndaatgal.mn системд дараах шинэ бүтээгдэхүүнүүдийг хөгжүүлж, туршин нэвтрүүлэв. Үүнд: Sicos мэдээллийн нэгдсэн системд:
--	--	--	--	--	--

					- БНСУ албан журмын даатгалын шинэ бүтээгдэхүүний хөгжүүлэлтийг хийж, амжилттай туршин нэвтрүүлэв. - Маргаан хянан шийдвэрлэх зөвлөлийн хурлын үйл ажиллагааг цахимаар бүртгэх, шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих, тайлан, судалгаа шинжилгээ хийх боломжийг бүрдүүлсэн бүтээгдэхүүнийг хөгжүүлж нэвтрүүлэв. - Нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөртэй ажил олгогчийн банкны дансыг цахимаар хаах, нээх үйл ажиллагааг хэрэгжүүлэх бүтээгдэхүүний хөгжүүлэлтийг хийж, Хаан банктай хамтран туршиж, нэвтрүүлэхэд бэлэн болголоо. Portal.ndaatgal.mn системд 2 шинэ бүтээгдэхүүн шинээр нэвтрүүлэв. <i>Иргэн тэтгэврээ цахимаар урьдчилан тооцоолох боломжийг бүрдүүлэв:</i> Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай хуульд нийцүүлэн даатгуулагч өөрийн өндөр насны тэтгэврийн хэмжээг урьдчилан тооцоолох цахим үйлчилгээг хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлсэн. Уг үйлчилгээ нь нийгмийн даатгалын мэдээллийн санд бүртгэлтэй даатгуулагчийн мэдээлэлд үндэслэн өндөр насны тэтгэврийн хэмжээг автомат тооцоолох боломжийг бүрдүүлж байна. Мөн даатгуулагч өөрийн ажилласан жил, хөдөлмөрийн хөлсний дундаж хэмжээ зэрэг үзүүлэлтүүдийг өөрчлөн оруулж, ирээдүйд авах боломжтой тэтгэврийн хэмжээг харьцуулан тооцоолох боломжтой болсон. Ингэснээр иргэд тэтгэврийн эрх үүсэх хугацаа, тэтгэврийн хэмжээнд нөлөөлөх хүчин зүйлсийг урьдчилан үнэлэх, хөдөлмөр эрхлэлт болон нийгмийн даатгалын шимтгэл төлөлттэй холбоотой шийдвэрээ мэдээлэлд үндэслэн гаргах нөхцөл бүрдсэн. <i>Иргэн илүү төлсөн шимтгэлийн буцаан олголт авах хүсэлтээ цахимаар гаргах боломжийг бүрдүүлэв:</i> Даатгуулагч үндсэн ажил олгогчоос гадна нэг буюу түүнээс дээш байгууллагад давхар ажил эрхэлж байх хугацаанд хуульд заасан хэмжээнээс илүү төлсөн шимтгэлээ буцаан авах хүсэлтээ цахимаар гаргах үйлчилгээг хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлсэн.
--	--	--	--	--	---

8.2	Ажил олгогч нийгмийн даатгалын шимтгэлээ нэхэмжлэхэд суурилан төлөх боломжийг банкуудтай хамтран бүрдүүлэх;		Үйлчилгээний тоо	1	4	Ажил олгогч болон даатгуулагч нийгмийн даатгалын шимтгэлээ нэхэмжлэлд суурилан цахимаар төлөх боломжийг бүрдүүлэх хүрээнд төлбөрийн нэхэмжлэл үүсгэх, төлбөрөө цахимаар төлөх, төлөлтийн мэдээллийг нийгмийн даатгалын мэдээллийн нэгдсэн системд автоматаар бүртгэх системийн хөгжүүлэлтийн ажил 90%-ийн гүйцэтгэлтэй хийгдэж байна. Мөн банкуудтай хамтран систем хоорондын мэдээлэл солилцоо, интеграцийн хөгжүүлэлт болон туршилтын ажлуудыг үе шаттайгаар хэрэгжүүлж байна.
8.3	Тэтгэвэр, тэтгэмжийн гүйлгээг НД-ын байгууллага цахимаар хийх боломжийг банкуудтай хамтран бүрдүүлэх /CGW/;		Үйлчилгээний тоо	-	1	Нийгмийн даатгалын байгууллага нь банкуудтай хамтран Corporate Gateway (CGW) үйлчилгээг ашиглан дансны хуулга татах, тэтгэвэр, тэтгэмжийн гүйлгээг цахим хэлбэрээр гүйцэтгэх боломжийг бүрдүүлэх ажлыг хэрэгжүүлж байна. Энэ ажлын хүрээнд Төрийн банк болон ХХБ-д байршиж буй байгууллагын дансны хуулгыг банкны системээс автоматаар татан авч, нийгмийн даатгалын мэдээллийн системтэй уялдуулан ашиглах боломжийг бүрдүүлэх хөгжүүлэлтийн ажлыг хэрэгжүүлж, нэвтрүүлэхэд бэлэн болгоод байна. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн гүйлгээг цахимжуулах зорилтын хүрээнд Хаан банкттай хамтран CGW үйлчилгээг ашиглан тэтгэмжийн гүйлгээний мэдээллийг банкны систем рүү цахимаар дамжуулах хөгжүүлэлтийн ажлын хэрэгжилт 30 хувьтай хийгдэж байна.
8.4	Нийгмийн даатгалын нэгдсэн мэдээллийн санг үүсгэж, баяжуулсан байх;		Мэдээллийн сангийн хэмжээ	2.8TB	3.0TB	Нэгдсэн мэдээллийн санг баяжуулж 2.9TB болгов. Орон нутгийн 21 аймаг, 320 сум, нийслэлийн 9 дүүрэг, 5 тасаг, 4 Нэг цэгийн үйлчилгээний төв дэх нийгмийн даатгалын байгууллагуудад өдөр бүр үүсгэн бүртгэж буй тэтгэвэр, тэтгэмж, сайн дурын даатгуулагч болон ажил олгогчийн мэдээлэл бодит цагийн горимоор (real-time) нэгдсэн мэдээллийн санд бүртгэгдэн, тогтмол баяжигдаж байна. Ингэснээр нийт 2.9 TB хэмжээтэй мэдээллийн сан бүрдээд байна. Ингэснээр Төрийн нэгдсэн мэдээлэл солилцооны ХУР системээр дамжуулан иргэн, даатгуулагч, ажил олгогч болон төрийн болон бусад байгууллагад үзүүлэх нийгмийн даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмж, цар

					хүрээ өргөжиж, хэрэглэгч бодит цагийн горимоор цахим үйлчилгээг шуурхай авах нөхцөл бүрдэв. Үүний дүнд 2026 оны эхний хагас жилийн байдлаар мэдээллийн нэгдсэн Sicos системээр 215.7 мянга, Portal.ndaatgal.mn системээр 126.1 мянга, нийт 341.8 мянган тэтгэвэр, тэтгэмжийн болон сайн дураар даатгуулах үйлчилгээ авах хүсэлтийг хүлээн авч нийт хүсэлтийн 97.5 хувийг шийдвэрлэсэн байна. Тухайлбал: - Сайн дурын даатгалын гэрээ байгуулах, сунгах, шимтгэл төлөх нийт 130.0 мянган хүсэлтийг хүлээн авч 99.6 хувийг шийдвэрлэсэн байна; - Хөдөлмөрийн чадвар түр алдсаны, нас барсан даатгуулагчийн ар гэрт олгох, жирэмсний болон амаржсаны тэтгэмж тогтоох, олгох, ажилгүйдлийн тэтгэмж тогтоох, олгох нийт 164.3 мянган хүсэлтийг хүлээн авч 96.5 хувийг шийдвэрлэсэн байна. - Өндөр нас, хөдөлмөрийн чадвар алдсаны болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр шинээр тогтоолгох, мөн тэтгэврээ өөрчлөн тогтоолгох 47.6 мянган иргэний хүсэлтийг хүлээн авч 94.9 хувийг шийдвэрлэсэн байна. - <i>Тэтгэвэр олголт:</i> *сар бүр дунджаар 562.7 мянган тэтгэвэр авагч (давхардсан тоогоор нийт 3.3 сая)-ийн тэтгэвэр олголтын тооцооллыг системээр тооцоолон цаг хугацаанд нь холбогдох банк руу илгээсэн байна. - <i>Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн тайлан:</i> *нийт 60.0 мянга гаруй ажил олгогчийн сар бүр илгээсэн 360.0 мянга орчим удаагийн, давхардсан тоогоор 5.0 сая орчим албан журмын даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг 100 хувь цахимаар хүлээн авч шийдвэрлэсэн байна. - <i>Эмнэлгийн хуудас:</i> *1051 эрүүл мэндийн байгууллагаас 78.4 мянган албан журмын болон сайн дурын даатгуулагчийн, хөдөлмөрийн чадвар түр алдсаны, 25.7 мянган даатгуулагчийн жирэмсний болон амаржсаны
--	--	--	--	--	---

						тэтгэмжийн, нийт 104.1 мянган эмнэлгийн хуудас цахимаар хүлээн авч үйлчилгээ үзүүлсэн байна. *Ажил олгогчоос цахимаар илгээсэн 72.5 мянган даатгуулагчийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудсыг хүлээн авч 83%-ийг нь шийдвэрлэж үйлчилгээ үзүүлсэн байна. - <i>Лавлагаа тодорхойлолт:</i> *Нийгмийн даатгалын Portal.ndaatgal.mn системээр 33.5 мянган даатгуулагч, 45.9 мянган ажил олгогч QR кодтой шимтгэл төлөлтийн лавлагаа, тодорхойлолт цахимаар авсан байна. - <i>E-Mongolia нэгдсэн портал:</i> Төрийн үйлчилгээний E-Mongolia нэгдсэн порталаар иргэд даатгуулагч, ажил олгогч нийгмийн даатгалын 12 төрлийн лавлагаа тодорхойлолтыг цахимаар авч байна.
8.5	Нэгдсэн мэдээллийн сангаас судалгаа, мэдээллийн боловсруулалт хийсэн байх;		Үйлчилгээний тоо	200	150	Улсын Их Хурлын гишүүд, яам, агентлаг, төрийн болон бусад байгууллага, хэрэглэгчдийн хүсэлтээр шаардлагатай мэдээллийн боловсруулалт, судалгаа, тооцооллыг гаргаж, мэдээллээр ханган ажиллалаа. Эхний хагас жилийн байдлаар нийт 60 гаруй удаагийн мэдээллийн боловсруулалт, судалгаа, тооцооллыг хийж, холбогдох байгууллагуудын шийдвэр гаргалт болон бодлого тодорхойлох хэрэгцээг хангахад дэмжлэг үзүүлэв. Томоохноос дурдвал: УИХГ нэр бүхий гишүүдийн хүсэлтээр: *200 хүртэл даатгуулагчтай ажил олгогчийн тоо, даатгуулагчийн тоо, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр шимтгэл төлсөн даатгуулагчийн тоо, төлсөн шимтгэлийн мэдээллийг 2025 оны байдлаар. *2025 оны байдлаарх даатгуулагчийн тоо, цалин хөлс, түүнтэй адилтгах орлого, ногдуулсан шимтгэлийн хэмжээг; *Иргэний хуулийн ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээ, тэдгээртэй адилтгах гэрээний дагуу шимтгэл төлсөн даатгуулагчийн тоо, төлсөн шимтгэлийн хэмжээг; *Сайн дураар даатгуулагчийн тоо, төлсөн шимтгэлийн хэмжээг;

					* Цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын мэдээллийг төсөвт байгууллага, ААНБ-аар ялган; * ХХДэХ-нээс дээш цалинтай даатгуулагчийн мэдээллийг. 18-24 насны даатгуулагчдын тоо, шимтгэлийн дүн, тэтгэвэр, тэтгэмжид зарцуулсан хөрөнгийг хэмжээг 2021-2025 онуудын байдлаар; <i>Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хүсэлтээр:</i> Нийгмийн даатгалын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах ажлын хүрээнд: *2025 оны байдлаарх албан журмаар даатгуулагчийн дэлгэрэнгүй мэдээллийг; *2024, 2025 онуудад шинээр даатгуулсан даатгуулагчийн мэдээллийг нийт 6 үзүүлэлтээр, ажил олгогчийн мэдээллийг нийт 11 үзүүлэлтээр; *Ажилгүйдлийн даатгалын сангаас ажилгүйдлийн тэтгэмж авагчдын мэдээллийг 2016-2025 оны байдлаар, нийт 11 үзүүлэлтээр; *Малчдын нийгмийн даатгалын хамрагдалтын мэдээллийг нас хүйс, шимтгэл төлсөн эсэх, шимтгэл төлсөн сар, тэтгэвэр тогтоолгосон эсэх зэрэг нийт 7 үзүүлэлтээр; *Өндөр насны тэтгэвэр тогтоолгоогүй нэрийн дансанд бүртгэлтэй нийт даатгуулагчдын 2014-2024 онуудын дэлгэрэнгүй мэдээллийг нийт 7 үзүүлэлтээр <i>Үндэсний статистикийн хороонд:</i> *ҮСХ-ны даргын 2013 оны 1/158 тоот тушаалаар батлагдсан маягтын дагуу 2025 оны 4-р улирал, 2025 оны жилийн эцэс, 2026 оны 1-р улирлын байдлаарх ААНБ-ын даатгуулагчдын тоо, цалин хөлс, түүнтэй адилтгах орлого, сарын дундаж цалинг өгөгдсөн интервал, хүйс, аймаг болон бүс, эдийн засгийн ангилал, ажил мэргэжлийн код, өмчийн хэлбэр, хариуцлагын хэлбэрээр нийт 34 хүснэгтэн мэдээлэл; *ҮСХ-ны даргын 2024 оны А/175 тоот тушаалаар батлагдсан маягтын дагуу нийгмийн даатгалын салбарын 2025 оны жилийн эцсийн байдлаарх нийт 28 хүснэгтэн мэдээлэл; *НДҮЗ-ийн 2025 оны “Нэрийн дансны 2024 оны орлогод тооцох хүүгийн хэмжээг тогтоох тухай” 10 дугаар тогтоолоор батлагдсан хүүгийн хэмжээгээр нийт 1.5 сая
--	--	--	--	--	---

						даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны 2024 оны жилийн эцсийн үлдэгдлийн тооцооллыг хийсэн. <i>Эдийн засаг, хөгжлийн яамны хүсэлтээр:</i> *Нийгмийн даатгалд даатгуулагчдын нас, хүйс, даатгуулагчийн төрөл, ажил мэргэжлийн ангилал, хөдөлмөр эрхэлж буй салбар, тухайн сарын цалин хөлс, ААНБ-ын төрөл хэлбэр зэрэг дэлгэрэнгүй мэдээллийг нийт 10 үзүүлэлтээр; <i>Татварын ерөнхий газрын хүсэлтээр:</i> *Нийгмийн даатгалын шимтгэл төлсөн ажил олгогч, даатгуулагчийн дэлгэрэнгүй мэдээллийг 2025 он, 2026 оны 1-р улирлын байдлаар; <i>Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газрын хүсэлтээр:</i> *Ирүүлсэн хүснэгтийн дагуу тэтгэвэр авагч, хөдөлмөрийн чадваргүй иргэний жагсаалтыг; <i>Боловсролын ерөнхий газрын хүсэлтээр:</i> *Жагсаалтаар ирүүлсэн иргэдийн хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон эсэх мэдээлэл; <i>Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төвийн хүсэлтээр:</i> *Хавсралтаар ирүүлсэн ажил мэргэжлийн ангиллын дагуу 2024-2025 оны байдлаар даатгуулагчдын дундаж цалингийн хэмжээ; <i>ЦЕГ-ын ЭЦА-ны хүсэлтээр:</i> *Нэр бүхий 16 яамны даатгуулагчдын мэдээллийг 2025 оны байдлаар. . . . гэх мэт.
8.6	Төрийн нэгдсэн мэдээлэл солилцооны ХУР системээр дамжуулан цахимаар мэдээлэл солилцох үйлчилгээг өргөжүүлэн хэвийн ажиллагааг хангасан байх;		Үйлчилгээний тоо	60	62	Төрийн нэгдсэн мэдээлэл солилцооны ХУР системээр дамжуулан цахим мэдээлэл солилцооны үйлчилгээг өргөжүүлж, хэвийн ажиллагааг хангах зорилтын хүрээнд иргэд даатгуулагч, ажил олгогчийн мэдээллийг агуулсан нийт 60 гаруй төрлийн сервисийн тасралтгүй, хэвийн ажиллагааг ханган ажиллалаа. Ингэснээр төр, хувийн хэвшлийн нийт 450 гаруй байгууллага ХУР системээр дамжуулан нийгмийн даатгалын мэдээлэл, үйлчилгээг бодит цагийн горимоор авч байна. <i>ХУР системд 3 сервисийг хөгжүүлэн хүргэв:</i>

						- Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, шалтгааныг магадалсан шийдвэрийн хуудас"-ыг англи хэл дээр хөрвүүлсэн хувилбарыг сервис хэлбэрээр хөгжүүлж хүргүүлэв. - Тухайн ажил олгогчид хамаарах даатгуулагчдын тухайн жилийн ажил эрхлэлтийн мэдээллийг ажил олгогчийн дугаар болон он тус бүрээр шүүх боломжтой сервисийг хөгжүүлэв. - Иргэний нийгмийн даатгалын мэдээлэл дамжуулах сервисийг шинээр боловсруулав. И-Монгол Академи УТУГ-т 4 сервис боловсруулан хүргүүлэв. - Ажилгүйдлийн тэтгэмж авах хүсэлтийг цахимаар хүлээн авах сервис; - Хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмжийн хүсэлтийг цахимаар хүлээн авах сервис; - Жирэмсний болон амаржсаны тэтгэмжийн хүсэлтийг цахимаар хүлээн авах сервис; - Иргэд, даатгуулагч тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны 2024 оны эцсийн үлдэгдлээ E-Mongolia системээр дамжуулан авах боломжийг бүрдүүлсэн.
8.7	Системийн аюулгүй байдал, тасралтгүй үйл ажиллагааг хангаж Үндэсний дата төвд нөөц сервер байршуулах;		Үйлчилгээний тоо	-	1	Системийн аюулгүй байдал, найдвартай ажиллагаа, тасралтгүй үйл ажиллагааг хангах зорилгоор мэдээллийн сангийн нөөц хуулбар (READ)-ыг үүсгэн Үндэсний дата төвд байршуулах бэлтгэл ажлыг хангаж, шаардлагатай техникийн тохиргоо, холболтын ажлыг гүйцэтгэсэн. Мөн нийгмийн даатгалын мэдээллийн системийн нөөцийг Үндэсний дата төвд 2026 оны III, IV улиралд багтаан байршуулахаар төлөвлөн ажиллаж байна.
3						
о						
9.1	Нийслэлийн Эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүдийн бичиж, олгосон цахим эмнэлгийн хуудасны үндэслэлийг хянах		Хяналт шалгалтын тоо	-	1	Эрүүл мэндийн байгууллагуудаас 2022-2025 онуудад бичиж олгосон хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудасны тоон үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийв.
			Хэрэгжилтийн хувь	-	100%	Судалгааг эрүүл мэндийн байгууллагуудаас бичиж олгосон хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудасны мэдээлэлд тулгуурлан өвчлөлийн бүтэц, нас, хүйсийн ялгаа, эдийн засгийн салбарын ангилал,

	хяналт, шалгалт зохион байгуулах;					тэтгэмжийн санхүүгийн ачааллыг тоон болон харьцуулсан аргаар хийв. Эмнэлгийн хуудасны бичилт, олголтыг 2022 оноос эхлэн цахим хэлбэрт шилжүүлснээр бодит өгөгдөлд тулгуурлан дүн шинжилгээ хийх боломж бүрдсэн ба 2022-2025 онуудад 2000 гаруй эрүүл мэндийн байгууллагаас давхардаагүй тоогоор 234,076 даатгуулагчид 505,091 эмнэлгийн хуудсыг бичиж, олгон ажил олгогч байгууллагаас 134.7 тэрбум, нийгмийн даатгалын сангаас 123.6 тэрбум нийт 258.3 тэрбум төгрөгийн хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг олгосон байна. Хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудас бичүүлсэн давтамжаар хамгийн өндөр 20 иргэн ба ажил олгогчийг судлан үзэхэд хөдөлмөрийн чадвар түр алдсаны эмнэлгийн хуудас олон давтамжтайгаар бичүүлсэн даатгуулагчдын 50 орчим хувийг Эрдэнэт үйлдвэр төрийн өмчит үйлдвэрийн газарт ажилладаг иргэд байгаа нь анхаарал татаж буй бөгөөд тухайн эмнэлгийн хуудас нь үндэслэлтэй бичигдсэн эсэх, үйлдвэрийн газарт хөдөлмөрийн аюулгүй байдлын хангуулах арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих зорилгоор аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дэргэдэх Эрүүл мэндийн магадлалын зөвлөлүүдэд удирдамжийн дагуу хяналт шалгалт хийх чиглэл өгч 21 аймаг, 8 дүүргийн магадлагч эмч нар улсын хэмжээнд нийт 88,574 эмнэлгийн хуудсыг хянан баталгаажуулан шийдвэрлэв. Нийслэлийн Эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүдийн бичиж, олгосон цахим эмнэлгийн хуудасны үндэслэлийг хянах хяналт, шалгалт 2026 оны 06 дугаар сарын 30-ны өдөр дуусахаар төлөвлөж байна. Төв зөвлөлийн магадлагч эмч нарын цахим хяналтаар улсын хэмжээнд хөдөлмөрийн чадвар түр алдалтын 70,895 эмнэлгийн хуудас хянасан дундаж 1.22 хоног, жирэмсний болон амаржсаны 16,731 эмнэлгийн хуудас хянасан дундаж 1.07 хоног, үйлдвэрлэлийн ослын улмаас олгосон хөдөлмөрийн чадвар түр алдалтын 1,308 эмнэлгийн хуудас хянасан дундаж 2.61 хоног байна.
--	--	--	--	--	--	---

9.2	Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоолгосон иргэдийн тоогоор улсын дундажаас өндөр, өсөлт их байгаа аймаг, дүүргүүдэд хяналт, шалгалт хийх, түүнийг бууруулах арга хэмжээ авч ажиллах;		Хяналт шалгалтын тоо	6	4	Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн Дахин магадлалыг 1 удаа (Ховд, Хөвсгөл, Баянхонгор, Хэнтий, Говьсүмбэр, Дорноговь, Сэлэнгэ аймгууд болон Сүхбаатар, Хан-Уул дүүрэгт), Хамтарсан магадлалыг Сүхбаатар, Баянгол дүүрэг, Хэнтий аймагт 3 удаа зохион байгуулав.
			Бууруулсан хувь	1.9%	3 %	Ховд, Хөвсгөл, Баянхонгор, Хэнтий, Говьсүмбэр, Дорноговь, Сэлэнгэ аймгууд болон Сүхбаатар, Хан-Уул дүүргийн Гэмтэл согогийн болон Чих, хамар, хоолойн өвчнөөр хөдөлмөрийн чадвар алдалтыг “Хугацаагүй”-гээр тогтоолгосон иргэдийн дахин магадлал зохион байгуулсан хугацаанд хөдөлмөрийн чадвар алдалттай иргэдийн тоог дунджаар 0.1 хувиар бууруулсан үзүүлэлттэй байна. Хамтарсан магадлал зохион байгуулсан хугацаанд Сүхбаатар, Баянгол дүүрэгт, Хэнтий аймагт Эрүүл мэндийн магадлалын төв зөвлөлийн хамтарсан магадлалаар хөдөлмөрийн чадвар алдалттай иргэдийн тоог 2.2 хувиар, нийт 2.3 хувиар бууруулсан үзүүлэлттэй байна.
9.3	Даатгуулагчид тусламж, үйлчилгээ үзүүлэх сэргээн засах төв болон сувиллыг сонгон шалгаруулах үйл ажиллагааг зохион байгуулж, тусламж үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулан ажиллах;		Гэрээ байгуулсан байгууллагын тоо	7	10	Сонгон шалгаруулалтад шалгарсан Тулга сувилал ОНӨААТҮГ, Оргил рашаан сувилал ХХК, Далд засал ХХК, Интенсивкаре ХХК, Тунгалаг Онги ХХК, Ээлтэй оточ сувилал, ЭМЖЖ ХХК, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, Номун сувилал ХХК, Багануур ТӨҮГ, Энх-Ундрага ХХК, ТӨБАСЭ ХХК, Сэмжид хужирт рашаан сувилал, Мангут ХХК Мойлтын тохоо сувилал зэрэг 12 байгууллагад "Даатгуулагчид үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний үеийн сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх гэрээ"-г байгуулан үр дүнг тооцон ажиллаж байна.
			Сувилуулсан даатгуулагчийн тоо	1123	1500	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний үеийн сэргээн засах тусламж, үйлчилгээ үзүүлэх 2026 онд 12 сувилалд нийт 318 даатгуулагч, хүнд 379.3 сая төгрөгийн сэргээн засах тусламж үйлчилгээг үзүүлсэн байна.
9.4	Даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох сунгах, цуцлах үйл ажиллагааг		Хэрэгжүүлсэн ажлын тоо	-	2	- Нийгмийн даатгалын ерөнхий газар болон Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай 2026 оны 03 дугаар сарын 10-ны өдөр НД31/26/ 26/22 дугаартай “Хамтран ажиллах гэрээ”-нд нэмэлт өөрчлөлт оруулж, гэрээний хоёрдугаар хавсралтаар Мэдээлэл солилцох

	харьяалал харгалзахгүйгээр, санамсаргүй түүврийн аргаар хуваарилан шийдвэрлэх арга хэмжээг авч ажиллах;					хүснэгт (ГБХНХ-ын сайд, Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/125, А/212 дугаар “Мэдээлэл солилцох тухай” хамтарсан тушаалын хавсралт)-ийн дагуу мэдээллийг харах боломжийг бүрдүүлэн ажиллав. -Эрүүл мэндийн яамны Стратеги төлөвлөлтийн газрын Эрүүл мэндийн инновац, цахим хөгжлийн хэлтсийн дарга, ЭМХТ-ийн Цахим хөгжлийн албаны дарга болон холбогдох мэргэжилтнүүдтэй Гэр бүл, хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны Нийгмийн даатгал, хуримтлалын сангийн бодлогын газрын шинжээч, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх МТТ-ийн дэд захирал, Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх ЭММТЗ-ийн магадлагч эмч нар 2026 оны 05 дугаар сарын 22-ны өдөр цахим мэдээлэл солилцох ажлыг эрчимжүүлэх талаар уулзалт зохион байгуулав.
			Хэрэгжилтийн хувь		100%	Мэдээлэл солилцох үйл явц 40% хэрэгжиж байна.
Стратегийн төлөвлөгөөний зорилго 4: Даатгуулагчид, үйлчлүүлэгчдийн хэрэгцээнд нийцсэн, нийгмийн хариуцлага бүхий тогтолцоог бүрдүүлж хэрэгжүүлэх;						
Зорилт 10. Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, хууль тогтоомж, тогтоол шийдвэр, эрх зүйн туслалцаа үзүүлэх, хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах, мэргэжил, ур чадвар, чадавхийг дээшлүүлэх, мэргэшүүлэх,						
10.1	Батлагдсан орон тоо, төсвийн хүрээнд үйл ажиллагаа явуулах, Нийгмийн даатгалын байгууллагын сул орон тооны захиалгыг Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлэх;	-	Сул орон тооны захиалгын тоо	36	Тухай бүр	Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газруудаас тухай бүр сул орон тооны захиалгыг авч, нэгтгэн, нийт 37 сул орон тооны захиалгыг 4 удаа Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлд хүргүүлсэн.
			Тогтоолын дагуу баталсан орон тоо	28 орон тоо нөхөгдсөн.		Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны дэргэдэх Төрийн албаны салбар зөвлөлөөс ирүүлсэн тогтоолын дагуу 18 хаагчийг хууль, журмын дагуу томилсон.
10.2	Нийгмийн даатгалын байгууллагын ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааны хөтөлбөрийн дагуу төлөвлөгөөг боловсруулж батлах, хэрэгжилтэд хяналт тавих;		Баталсан төлөвлөгөө	1	1	Нийгмийн даатгалын байгууллагын ажилтан, албан хаагчдын нийгмийн баталгааг хэрэгжүүлэх 2026 оны төлөвлөгөөг баталсан. Төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 22 арга хэмжээг төлөвлөв.
			Төлөвлөгөөний хэрэгжилт	100%	100%	Төлөвлөгөөний 5 зорилтын хүрээнд 22 арга хэмжээнээс эхний хагас жилд гүйцэтгэх 17 арга хэмжээний хэрэгжилт 100 хувьтай байна.
			Тусламжийн дүн	3,560.9 сая төгрөг	Тухай бүр	Хууль тогтоомж, байгууллагын дотоод журамд заасны дагуу хүндэтгэх шалтгаантай хүсэлт гаргасан 5 албан хаагчдад буцалтгүй тусламж. Хүүхэд хамгаалах өдрийг

						тохиолдуулан албан хаагчдын 109 хүүхдүүдэд хүндэтгэл үзүүлсэн ба нийт 10,290.0 сая төгрөгийн тусламж, дэмжлэгийг олгосон.
10.3	Нийгмийн даатгалын ерөнхий газраас гаргасан журам, дүрэм, зааврыг эрх бүхий байгууллагад бүртгүүлэх, хүчингүй болсон актыг хасуулах ажлыг зохион байгуулах;		Бүртгүүлсэн дүрэм, журмын тоо	6	Тухай бүр	Тайлант хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий газраас гаргасан, эрх бүхий байгууллагад бүртгүүлэх Захиргааны хэм хэмжээний акт байхгүй байсан болно.
			Хүчингүй болгосон актын тоо	2		
10.4	Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг хэрэгжүүлэх;		Баталсан төлөвлөгөө	1	1	Ёс зүйн дэд хорооны дарга 2026 онд хорооны Гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг баталж төлөвлөгөөнд 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөв.
			Сургалт зохион байгуулсан тоо	7	8	Тайлант хугацаанд 8 удаагийн сургалтыг зохион байгуулж, давхардсан тоогоор 1,680 албан хаагчдыг хамруулав.
			Төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн	100%	100%	Төлөвлөгөөнд тусгагдсан 9 арга хэмжээг 100 хувь хэрэгжүүлэв. Үүнд: - 8 удаагийн сургалт; - 1 нөлөөллийн арга хэмжээ; - 4 зөвлөмж, чиглэл; - 3 Дэд хорооны хурал; - Хүлээн авсан гомдол, мэдээлэл-5, шийдвэрлэсэн гомдол, мэдээлэл -5
10.5	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2026 оны төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний хэрэгжилтийг хангах;		Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь	-	100%	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2026 оны арга хэмжээний төлөвлөгөөг баталж Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрууд, Дотоод нэгжид тус тус хүргүүлсэн. Тайлант хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий газраас гаргаж буй хэм хэмжээний актыг батлах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог дэмжих үүднээс хэм хэмжээний актад санал авах ажиллагааг өргөжүүлэх төлөвлөгөө баталж, хэрэгжүүлсэн. Нийгмийн даатгалын ерөнхий газрын дарга болон салбар аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын төсвийн шууд захирагчийн мэдээллийн олон нийтэд ил тод байршуулсан, Нийгмийн даатгалын салбарын

						шилэн дансанд байршуулахаар хуулчилсан мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулан ажилласан. Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрт тусгагдсан тус газрын чиг үүрэгт хамаарах 6 арга хэмжээний тайлант хугацааны хэрэгжилт 100% байна.
10.6	Жендэрийн эрх тэгш байдлыг ханган Жендэрийн дэд зөвлөлийн 2026 оны төлөвлөгөөг боловсруулан баталж, холбогдох газарт судалгаа мэдээг хүргүүлэх;	-	Баталсан төлөвлөгөө	1	1	Жендерийн салбар зөвлөлийн дарга 2026 оны ажлын төлөвлөгөөг батлав. Төлөвлөгөөнд 9 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны явц, үр дүнгийн жилийн мэдээ цахим хэлбэрээр авах систем”-д холбогдох мэдээллийг хугацаанд нь мэдээлэв. 2026 оны 03 дугаар сард салбарын хэмжээнд “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах сар, Харилцан хүндэтгэе” аяныг хэрэгжүүлэх төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг 100 хувь ханган, тайланг Гэр бүл, хөдөлмөр, нийгмийнхамгааллын яаманд хүргүүлэв.
			Судалгаа	-	1	Хэрэгжүүлэх хугацаагүй болоогүй болно.
			Сургалт	1	2	Тайлант хугацаанд холбогдох албан хаагчдыг 3 удаагийн сургалт, хэлэлцүүлэг, зөвлөгөөнд хамруулав. Үүнд: - 2026.01.08-нд “Эрэгтэйчүүдийн жендэрийн эрх тэгш байдал” уулзалт, өдөрлөгт 1 албан хаагч; - 2026.05.09-нд салбар зөвлөлийн хуралдаан, зөвлөгөөнд 5 албан хаагч; - 2026.06.09-нд “Монгол Улсад Жендэрийн мэдрэмжтэй, хүртээмжтэй нийгмийн хамгааллын тогтолцоог сайжруулах нь” хэлэлцүүлэгт 2 албан хаагч тус тус оролцов. Сургалт, зөвлөгөөнд хэлэлцэгдсэн асуудлаар нийт албан хаагчдад 2 удаа мэдээлэл өгөв.
10.7	Албан бичгийг “Цахимаар албан бичиг солилцооны дундын систем”-тэй холбогдсон байгууллагуудтай цахимаар солилцох, тоон гарын үсгээр		Тоон гарын үсгийн хэрэглээний хувь	88%	100%	Албан бичгийг стандартын дагуу боловсруулан хос бичгээр албан хэрэг хөтлөлтийн нэгдсэн систем /intranet.gov.mn/-д бүртгэн холбогдох байгууллагууд руу тоон гарын үсгээр баталгаажуулан илгээж удирдлагуудын тоон гарын үсгийн хэрэглээ 100 хувьд хүрсэн.
			Албан бичиг цахимаар	100%	100%	Нийгмийн даатгалын 32 байгууллага цахим системтэй холбогдсон байгууллагуудтай албан бичгийг

	100 хувь баталгаажуулан хүргэх;		солилцох хувь			100 хувь цахимаар илгээж, хүлээн авч албан бичгийг солилцож байна Нийгмийн даатгалын ерөнхий газарт цахимаар 2026 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн байдлаар 2,213 албан бичгийг бусад газруудаас ирүүлсэн байна.
10.8	Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох, баталгаажуулах, сэргээх шалгалт зохион байгуулах;		Шалгалтын тоо	1	2	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2026 оны “Ажлын хэсэг байгуулах, удирдамж батлах тухай” А/50 дугаар тушаалын дагуу Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох, баталгаажуулах шалгалтыг 2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулав.
			Сургалтын тоо	9	15	Шалгалтад хамрагдах болон шинээр томилогдсон албан хаагчдад 10 удаагийн сургалтыг зохион байгуулав.
10.9	Нийгмийн даатгалын байгууллагын хүний нөөцийн чадавхийг бэхжүүлэх, ажилтнуудыг сургаж хөгжүүлэх;		Сургалтын тоо	3,153	34,681	Нийгмийн даатгалын байгууллагын албан хаагчдад зориулсан танхимаар болон цахимаар 739 удаагийн сургалтыг зохион байгуулж сургалтын “Динамик платформ”-д 4 модуль бүхий 34 сургалтыг байршуулан, албан хаагчид цаг хугацаа харгалзахгүйгээр суралцах боломжийг бүрдүүлсэн. Мөн долоо хоног бүр салбарын нийт албан хаагчдад 0.5-1 цагийн мэдээлэл, сургалт тогтмол зохион байгуулж байна.
			Албан хаагчдын тоо	46,908	51,599	Сургалтад давхардсан тоогоор 34,554 албан хаагч хамрагдав.
10.10	“Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн удирдлагын нэгдсэн цахим систем”-ийг турших, нэвтрүүлэх ажлыг зохион байгуулах;		Нэвтрүүлсэн байгууллагын тоо	-	31	Нийгмийн даатгалын 32 байгууллага “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн удирдлагын нэгдсэн цахим систем”-д байгууллагын болон албан хаагчийн 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 100% хугацаанд нь оруулав
Зорилт 11. Ажил олгогч, даатгуулагч, иргэдэд нийгмийн даатгалын хууль эрх зүйн мэдлэг олгох замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах;						
11.1	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд Нийгмийн даатгалын хууль, тогтоомжийн талаар сургалт зохион байгуулах;		Зохион байгуулсан сургалтын тоо	-	2	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд Нийгмийн даатгалын хууль, тогтоомжийн талаар 1 удаагийн сургалт зохион байгуулав.
			Сургалтад хамрагдсан хүний тоо	-	100	Сургалтад 52 хөгжлийн бэрхшээлтэй иргэн хамрагдаж, сургагч багшийн сургалт хийв.

11.1	Ажил олгогч, даатгуулагч, иргэдийн нийгмийн даатгалын талаарх мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн сургалт зохион байгуулах;		Сургалтын тоо	3775	3800	Ажил олгогч, даатгуулагч, иргэдийн нийгмийн даатгалын талаарх мэдлэгийг дээшлүүлэхэд чиглэсэн 1,348 сургалт зохион байгуулав. Дараах сургалтуудыг салбарын хэмжээнд 1 цаг хугацаанд, бүх байгууллагууд хийж хэвшсэн. - Ажил олгогчоос ирсэн хүсэлтээр; - Сар бүрийн 2 дахь 7 хоногийн Лхагва гарагт танхимын сургалт; - Сар бүрийн 4 дэх 7 хоногийн Лхагва гарагт практик сургалт; - Сар бүр Зоом, лайв сургалт; - МУИС, БС-ийн оюутнууд; - ТМЗН-тэй хамтарсан уралдаанд оролцогч оюутнууд; - ТМЗН-ийн татварын мэргэшсэн зөвлөхүүдэд; - Төрийн болон төрийн бус 170 гаруй дээд шатны байгууллагуудад хүсэлт хүргүүлэн, салбар нэгж, харъяа байгууллагуудыг нь хамруулан сургалт хийж байна.
			ААНБ-ын тоо	18,473	18,500	Сургалтад 6,820 ажил олгогч хамрагдав.
			Иргэд, даатгуулагчийн тоо	208,458	209,000	Сургалтад 86,611 даатгуулагч, иргэд хамрагдав.